2018 он

# ДУНДГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА 2018

**Byambasuren**

**Дундговь аймаг**

**2018 он**

**Судалгааны багийн зөвлөх**

Техник, мэргэжлийн боловсрол сургалтын салбарыг дэмжих 2 төслийн зөвлөх багш, Ч.Наранбилэг

БСШУСЯ-ны Боловсролын хүрээлэнгийн ДБМБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан Р.Нурбек

Говийн бүсийн арга зүйн төвийн менежер О.Саруул

Говийн бүсийн арга зүйн төвийн арга зүйч багш Л.Баасансүрэн

ХХҮГ-ын ахмад мэргэжилтэн Р.Чанцал

Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн дарга Б. Энхтуяа

Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Бямбасүрэн

Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн мэргэжилтэн С.Доржханд

**Судалгааны баг**

**Аж ахуйн нэгжүүдээс авсан тоон судалгааг нэгтгэсэн:**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн Э.Мөнхзул

Татварын хэлтсийн улсын байцаагч Н.Долгорсүрэн

**Хувиараа хөдөлмөр эрхлэгчээс авсан тоон судалгааг нэгтгэсэн:**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн Ц.Оюун-Эрдэнэ

**Ажилгүй иргэдээс авсан тоон судалгааг нэгтгэсэн:**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга Э.Цэвэлмаа

МСҮТ-н багш О.Цэнгэлмаа

**Ажиллаж байгаа залуучуудаас авсан судалгааг нэгтгэсэн:**

Говийн бүсийн арга зүйн төвийн арга зүйч Д.Галбадрах

МСҮТ-н багш З. Цолмонгэрэл

**Малчин өрхөөс авсан судалгааг нэгтгэсэн:**

Хүнс хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн Ж.Батбилэг

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Уянга

**МСҮТ-н суралцагчдаас авсан судалгааг нэгтгэсэн:**

МСҮТ-ийн дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн А.Эрдэнэчимэг

МСҮТ-ийн нийгмийн түншлэл хариуцсан мэргэжилтэн Н.Ганцэрэн

Энэхүү номыг хэвлүүлж олон нийтийн хүртээл болгоход санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байгууллагуудад талархал илэрхийлье.

Европын холбооны “Техник мэргэжлийн боловсрол сургалтын салбарыг дэмжих төсөл-2”-50%

Дундговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 34%

Дундговь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар 16%

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮДИЙН ХӨДӨЛМӨР, ОЮУН УХААН ШИНГЭСЭН ХАМТЫН БҮТЭЭЛ БОЛНО

## Contents


ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР ..... 4

ӨМНӨХ ҮГ ..... 5

БҮЛЭГ 1. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН ТООН БОЛОН ЧАНАРЫН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ..... 6

1.1 СУДАЛГАА ХИЙХ ҮНДЭСЛЭЛ ШААРДЛАГА ..... 6

**1.2 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО** ..... 6

1.3 судалгааны хамрах хүрээ ..... 6

1.4 судалгааны түүвэрлэлт ..... 6

1.5 судалгааны зохион байгуулалт ..... 7

1.5.1 Мэдээлэл цуглуулалт ..... 7

1.5.2 Мэдээлэл боловсруулалт ..... 7

1.5.4 ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ ..... 7

БҮЛЭГ 2. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ..... 10

2.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ ..... 10

БҮЛЭГ 3. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН СУДАЛГААНЫ ДҮН ..... 14

3.1 АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГААС АВСАН ТООН СУДАЛГААНЫ ДҮН ..... 14

3.2 ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДЭЭС АВСАН ТООН СУДАЛГААНЫ ДҮН ..... 25

3.3 МАЛЧДААС АВСАН СУДАЛГААНЫ ДҮН ..... 35

3.4 АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ДҮН ..... 44

3.5 Их дээд сургуульд суралцаж буЙ залуучуудаас АВСАН СУДАЛГААНЫ ДҮН ..... 56

3.5 МСҮТ-н суралцагчдаас авсан судалгааны дүн ..... 64

3.7 Ажиллаж байгаа залуучуудаас АВСАН СУДАЛГААНЫ ДҮН ..... 68

бүлэг 4 ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН ТООН ..... 74

СУДАЛГААНД ХИЙСЭН ДҮГНЭЛТ ..... 74

Хавсралт 1 ..... 86

Хавсралт 2 ..... 94

Хавсралт 3 ..... 97

Хавсралт 4 ..... 100

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | | |
|---|---|---|
| 1. | АЗДТГ | Аймгийн Засаг даргын тамгын газар |
| 2. | ХХҮГ | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар |
| 3. | ХХААГ | Хүнс хөдөө аж ахуйн газар |
| 4. | МСҮТ | Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв |
| 5. | ХОХБТХ | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс |
| 6. | АХС | Ажиллах хүчний судалгаа |
| 7. | ХНХА | Хөдөлмөрийн насны хүн ам |
| 8. | ЭЗИХА | Эдийн засгийн идэвхтэй хүн ам |
| 9. | АХОТ | Ажиллах хүчний оролцооны түвшин |
| 10. | АХИЕК | Ажиллах хүчний идэвхийн ерөнхий коэффицент |
| 11. | ЭЗА | Эдийн засгийн ачаалал |
| 12. | ХЭТ | Хөдөлмөр эрхлэлтийн түвшин |
| 13. | АТ | Ажилгүйдлийн түвшин |
| 14. | ЭЗИБТ | Эдийн засгийн идэвхгүй байдлын түвшин |
| 15. | LMIS | Хөдөлмөрийн зах зээлийн програм |
| 16. | SPSS | Судалгааны мэдээлэл боловсруулах програм |

# ӨМНӨХ ҮГ

Дундговь аймгийн хувьд жил бүр хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийг статистик болон барометрийн судалгааны тоон үзүүлэлтэд үндэслэн гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн салбарын хүрээнд дээрх тоон мэдээллийг ашиглаж байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь тус судалгааны тоон үзүүлэлтийн цар хүрээг нэмэх, олон талын үзүүлэлт, оролцоог хангах зорилгоор 2018 онд орон нутагт хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн тоон болон чанарын судалгааг Увс аймгийн хөдөлмөрийн зах зээлийн 2015 онд хийсэн судалгааны үр дүн, туршлагад үндэслэн “Техник, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг дэмжих –2” төсөл, аймгийн Засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Татварын хэлтэс, Статистикийн хэлтэс, Говийн бүсийн арга зүйн төв, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв хамтран зохион байгууллаа.

Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн тоон болон чанарын судалгаа нь төрийн байгууллагын бодлогын баримт бичгийн төлөвлөлтийн тоон үзүүлэлт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлж дүгнэлт, зөвлөмж, мэргэжлийн боловсрол сургалтын болон хөдөлмөр эрхлэлтийн салбарын бодлого тодорхойлогчид, цаашлаад аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн мэдээллийн хэрэгцээнд нийлүүлж байна.

Энэхүү судалгааг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар санаачлан зохион байгуулахад санхүү, техник тоног төхөөрөмж, арга зүйгээр хангаж ажилласан Европын холбооны “Техник мэргэжлийн боловсрол сургалтын салбарыг дэмжих төсөл-2”, Говийн бүсийн арга зүйн төвийн хамт олонд гүн талархал илэрхийлье.

# БҮЛЭГ 1. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН ТООН БОЛОН ЧАНАРЫН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

## 1.1 СУДАЛГАА ХИЙХ ҮНДЭСЛЭЛ ШААРДЛАГА

Дундговь аймгийн Хөдөлмөрийн хэлтэс нийгмийн түншлэлийн хүрээнд 2015 онд хөдөлмөрийн зах зээлийн LMIS програмд бүртгэлтэй ажилгүй иргэдийн нөхцөл байдлын шинжилгээ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 2017 онд ажил олгогчдын хэрэгцээ тодорхойлох судалгааг зохион байгуулж, хөдөлмөр эрхлэлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, МБСБайгууллага элсэлт авахад суурь мэдээлэл болгон ашиглаж байсан.

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд сүүлийн 2 жилийн дунджаар 100 иргэнд мэргэжил эзэмшүүлэхэд 50 хувь нь ажлын байраар хангагддаг, МСҮТөвийг жилд 300 иргэн төгсөж 85 хувь нь ажлын байраар хангагддаг бол 45 хувь нь мэргэжлээрээ ажилладаг байна.

Хөдөлмөрийн зах зээлийн LMIS програмд бүртгэлтэй ажилгүй иргэдээс дээд боловсролтой иргэдийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулахад жилийн өсөлт нь дунджаар 60-70 хувьтай, ажилгүйдлийн түвшин тогтвортой буурахгүй байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тооцохгүйгээр сургалт зохион байгуулж, мэргэжилтэй ажилгүйчүүд, ялангуяа дээд боловсролтой ажилгүйчүүдийн тоог жилээс жилд нэмэгдэхэд хүргэж байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг хийх нь хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага, их дээд сургуулийн элсэлт, төгсөлт, ажил олгогчийн хэрэгцээ, шаардлагыг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулж эрэлт, нийлүүлэлтийн талаар илүү бодитой мэдээлэл гаргаж олон нийтэд хүргэх нөхцөлийг бүрдүүлэх юм.

## 1.2 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Дундговь аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судалж, тодорхойлох.

## 1.3 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажиллаж буй залуучууд, малчин өрх, ажилгүй иргэн, их дээд сургууль, МСҮТ, политехник коллежид суралцаж буй оюутан, суралцагчид.

## 1.4 СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ

**Ажил олгогч буюу ААН байгууллага:** 2018 оны 4-р сарын байдлаар татварын мэдээллийн санд бүртгэлтэй нийт 1089 ААН байгууллагаас 354 ААН байгууллага буюу 32.5 хувийг түүвэрлэн хамруулсан.

**Хувиараа хөдөлмөр эрхлэгч:** 2018 оны 4-р сарын байдлаар татварын болон ХХҮГазрын мэдээллийн санд бүртгэгдсэн 718 ХХЭрхлэгчээс 436 буюу 60,7 хувь

**Малчин өрх:** 2017 оны мал тооллогын судалгаагаар **5**880 малчин өрх тоологдсон тэдгээрийн 710 өрх буюу 12 хувь

**МСҮТ суралцагчид:** Дундговь аймаг дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2017-2018 оны хичээлийн жилд нийт 512 суралцагчтайгаар үйл ажиллагаа явуулж 2017 оны 12 сард 100 мэргэжилтэй ажилтан хөдөлмөрийн зах зээлд бэлтгэн гаргасан. 2018 оны 04 дүгээр сарын байдлаар 412 суралцагч суралцаж байгаагаас хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд 362 суралцагч буюу 87,8 % нь хамрагдсан.

**Ажилгүй иргэн:** Статистикийн хэлтсийн түүвэр судалгааны тархалтаар аймгийн хэмжээнд ажилгүй иргэн 1696, хүн ам өрхийн мэдээллийн сангийн судалгаагаар хөдөлмөр эрхэлдэггүй хөдөлмөрийн насны 3005 иргэн бүртгэлтэй байснаас Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд дахин нягталж судалгаа авах хугацаанд ажилгүй байсан 2060 ажилгүй иргэнийг судалгаанд хамруулсан.

**Ажиллаж буй залуучууд:**

Хөдөлмөрийн зах зээлийн LMIS програмд бүртгэлтэй хөдөлмөр эрхэлж буй 2463 ажилтан, эдгээрийн 260 буюу 10 хувийг тус тус судалгаанд хамруулсан.

### 1.5 СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

#### 1.5.1 Мэдээлэл цуглуулалт

Техник, мэргэжлийн боловсрол сургалтын салбарыг дэмжих 2 төслийн түгээн дэлгэрүүлж буй шилдэг туршлага болох Увс аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааны арга зүйгээр Дундговь аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг зохион байгуулсан.

Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны ажлын хэсгийг аймгийн Засаг Даргын 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/102 тоот захирамжаар ЗДТГазрын нийгмийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг, сумдад Засаг даргаар ахлуулсан хөдөлмөрийн зах зээлийн судалгаа зохион байгуулах ажлын хэсэг тус тус байгуулан ажилласан.

2018 оны 3-р сарын 18-20-ны өдрүүдэд мэргэжлийн боловсрол, сургалтын болон хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн салбар зөвлөлийн дарга, гишүүд, сумдын Засаг дарга, ажил олгогчид, судлаачдад хөдөлмөрийн зах зээлийн тоон ба чанарын судалгааны арга зүйн сургалт зохион байгуулж чадавхжуулсан.

Судалгааны мэдээллийг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, ажил олгогчдын судалгааг сумдын татварын улсын байцаагчид, ажиллаж буй залуучууд, ажилгүй иргэдийн судалгааг ХХҮГазрын мэргэжилтнүүд, МСҮТөвийн суралцагчдын судалгааг МСҮТ-ийн багш нар, малчдын судалгааг сумдын Мал үржлийн тасгийн мэргэжилтнүүд, статистикийн хэлтсээс хөдөмөр эрхлэлтийн тоо үзүүлэлтийг тус тус цуглуулж мэдээллийн санд шивж оруулсан.

#### 1.5.2 Мэдээлэл боловсруулалт

Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны нэгтгэлийн ажлын хэсгийг Дундговь аймгийн Засаг даргын 2018 оны 4 дүгээр сарын 20-ны А/184 дугаар захирамжаар АЗДТГ-ын ХОХБТХ-ийн даргаар ахлуулж 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Мэргэшсэн зөвлөх багшаар судалгааны нэгтгэлийн багийн гишүүдэд “SPSS” програмын ашиглалт болон хөдөлмөрийн зах зээлийн судалгааны нэгтгэлийн ара зүйн сургалтыг 4 дүгээр сарын 23-24 өдрүүдэд зохион байгуулж, судалгааны нэгтгэлийн багийн гишүүдийг чадавхжуулсан. Судалгааны нэгтгэлийн багийн гишүүд 352 ажил олгогч, 436 хувиараа хөдөлмөр эрхлэгч, 711 малчин өрх, 2060 ажилгүй иргэн, 581 ажиллаж буй залуучууд, 362 МСҮТ суралцагчдаас авсан судалгааг 6 баг болж нэгтгэсэн.

### 1.5.4 ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

**Хөдөлмөр**

Оюуны болон биеийн хүчний ажлыг хамруулсан өргөн хүрээтэй ойлголт бөгөөд ажил эрхлэх чадамжийг ойлгоно.

**Ажил эрхлэлт**

Ажилтан болон ажил олгогчийн хооронд үүссэн эрх зүйн харилцаа буюу гэрээний үндсэн дээр хийгдэж буй үйл ажиллагааг ойлгоно.

**Модуль**

Тодорхой ажил мэргэжлийн чадамж эзэмшүүлэхэд чиглэсэн харилцан уялдаа бүхий сургалтын нэгж ажилбар

**Мэргэжил**

Тодорхой ажил хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогцыг

**Мэргэжлийн боловсрол**

Мэргэжлийн ур чадварыг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулаттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг

**Ажил олгогч**

Эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг бие даан гаргаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон ашиг буюу ашиг олох боломжоос шууд хамаарах бизнестээ урт хугацаагаар нэг буюу түүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн болон бусад гэрээ, тохиролцооны үндсэн дээр авч ажиллуулж буй эзэн, байгууллагын удирдлагыг хэлнэ.

**Аж ахуйн нэгж**

Улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээдийг

**Байгууллага**

Тодорхой чиг үүрэг, бүрэн эрх бүхий хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн этгээдийг хэлнэ.

**Салбар**

Салбар нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг нэгж бөгөөд компанийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь, түүнчлэн төлөөлөгчийн газрын үүргийг гүйцэтгэхийг хэлнэ.

**Хувиараа хөдөлмөр эрхлэгч**

Дангаараа буюу бусадтай хамтран өөрийн багаж, тоног төхөөрөмж, бусад материалыг ашиглан эдийн засгийн үйл ажиллагааг хараат бусаар явуулж, урт хугацаагаар ажилтан авч ажиллуулдаггүй /богино хугацаагаар түр ажиллуулж болно/, бизнесийнхээ үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрийг бие даан гаргадаг иргэнийг хэлнэ.

**Мал аж ахуй эрхлэгч**

Жилийн дөрвөн улиралын туршид өөрийн мал аж ахуйг эрхэлж, түүний бүтээгдэхүүн, ашиг шимээр орлого олж, амьжиргааны эх үүсвэрээ хангаж буй иргэнийг хэлнэ.

**Өрх**

Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо гэр бүл ураг төрөл болон хамаатан садны холбоотой хүмүүс, зарим гишүүд нь огт хамааралгүй байж болно. Өрх нь гэр бүл гэдэг ойлголтоос ялгаатай. Нэг өрхөд нэг болон хэд хэдэн гэр бүл амьдардаг байж болно.

**Малчин өрх**

Жилийн 4 улиралын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг хэлнэ.

**Мал бүхий өрх**

Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөж үржүүлдэг өрхийг хэлнэ.

**Малтай өрх**

Мал бүхий өрх, малчин өрхийн нийлбэрээр тодорхойлогдно.

**Малчид**

Жилийн 4 улиралын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа иргэдийг хэлнэ.

**Ажиллагч**

Ажиллагч гэдэг нь цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэнийг ойлгоно. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ.

**Цалин хөлстэй ажиллагч**

Хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан, эсвэл аман гэрээ болон хоёр талын тохиролцоогоор ажилладаг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг, ажил олгогчдод ажил, үйлчилгээ үзүүлснийхээ төлөө мөнгөн ба мөнгөн бус хэлбрээр цалин хөлс авдаг иргэнийг хэлнэ.

**Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч**

Мал аж ахуйгаа бусад өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд цалин хөлсгүй оролцон хувийн хэрэглээгээ хангаж буй тухайн өрхийн гишүүн болон тухайн өрхөд хамт амьдрахгүйгээр аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд нь оролцож байгаа иргэнийг хэлнэ.

**Ажилгүй иргэн**

Тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг ойлгоно.

**Бүртгэлтэй ажилгүй иргэд**

Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс болон хөдөлмөрийн биржид бүртгүүлсэн иргэдийг бүртгэлтэй ажилгүй иргэдэд хамруулна.

**Өрхийн тэргүүлэгч**

Өрхийн тэргүүлэгч гэдэг нь бусад гишүүд нь өрхийн тэргүүн хэмээн хүлээн зөвшөөрсөн өрхийн гишүүн бөгөөд насанд хүрсэн хүн байна. Хэрэв тухайн сууцанд нэгээс олон өрх амьдран сууж байвал төдий тооны өрхийн тэргүүн байна.

**Хөдөлмөрийн насны хүн ам**

Нийт хүн амаас эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох чадваргүй хүүхэд болон өндөр настнуудыг хассан ялгавраар тодорхойлогдоно.

**Эдийн засгийн идэвхтэй хүн ам**

Үндэсний тооцооны системийн хүрээнд, тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна.

**Хөдөлмөр эрхлэлтийн эрсдэл**

ОУХБ-ын тодорхойлсноор хөдөлмөрийн гэрээ нь хязгаарлагдмал, ажлын байрны аюулгүй байдал алдагдахад хууль ёсны туслалцаа авах боломжгүй, ажлын хэмжээ, цалин бага, мэргэжлээс шалтгаалсан өвчин, гэмтэл авах өндөр эрсдэлтэй ажлыг хэлнэ.

## БҮЛЭГ 2. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 2.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

2017 оны жилийн эцсийн мэдээгээр аймгийн хүн амын тоо 46383 болж өмнөх оноос 868 хүнээр буюу 1.85 хувиар өссөн нь Монгол улсын хүн амын 1.5 хувийг эзэлж байна. Тус аймгийн хувьд 15 сумын 13 суманд хүн амын тоо 0.3-3.7 хувиар өсч, 2 суманд буурсан байна. Нийт хүн амын 49.8 хувь буюу 23078 нь эмэгтэй, 50.2 хувь буюу 23305 нь эрэгтэйчүүд байна.

**График 1 2017 оны хүн амын нас, хүйсийн суварга**




Дээрх нас хүйсийн суваргаас харвал нийт хүн амын дунд 0-4 насныхан хамгийн өндөр хувийг эзэлж хүйсийн харьцаа хэвийн байна. Нас хүйсийн суваргын дунд хэсгээр цулхийсэн байгаа нь нийт хүн амын дунд 15-34 насны залуучууд гол хэсгийг бүрдүүлж байна. Насны бүлэг тус бүрд хүйсийн харьцаа хэвийн байгаа бол 50 болон түүнээс дээш насныханд эмэгтэйчүүдийн эзлэх хувь илүү байгаа нь тухайн насны ангилалд эрэгтэйчүүдийн нас баралт илүү байгаа гэж дүгнэхэд хүрч байна.

**График 2 Хүн амын насны бүтэц /хувиар/**




2017 оны байдлаар нийт хүн амын 29.0 хувийг 0-14 насны хүүхэд, 65.8 хувийг 15-64 насны хүмүүс, 5.2 хувийг 65 ба түүнээс дээш насны хүн ам эзэлж байна. Энэ нь өнгөрсөн онтой

харьцуулахад нийт хүн амын дунд 65-аас дээш насныхан болон 0-14 насныханы эзлэх хувь өссөн нь харагдаж байна.

**График 3 ХНХА, ажиллах хүч, ажиллагсадын тоон өсөлт /2013-2017/, хувиар**




2017 онд нийт хүн амын тоо өсөхтэй уялдан хөдөлмөрийн насны хүн ам 30528 болж өмнөх оноос 1.7 хувиар өссөн байна. Хөдөлмөрийн насны нийт хүн амын 77.7 хувь буюу 23.7 мянга нь эдийн засгийн идэвхитэй хүн ам, ЭЗИХАмын 95.4 хувь буюу 22.6 мянга нь ажиллагчид байна.

**Хүснэгт 1 Ажил эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд**

| **Ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд** | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Он** | Нийт хүн амын тоо | Хөдөлмөрийн насны хүн ам | Ажиллах хүч | Ажиллагчдын тоо | Эдийн засгийн идэвхгүй хүн ам | Бүртгэлтэй ажилгүйчүүд |
| **2010 он** | 45.9 | 28.5 | 24.2 | 21.8 | 9224 | 848 |
| **2011 он** | 45.0 | 29.1 | 24.4 | 22.3 | 7455 | 638 |
| **2012 он** | 44.6 | 29.7 | 23.4 | 21.4 | 7514 | 828 |
| **2013 он** | 44.4 | 29.7 | 21.6 | 20.2 | 9272 | 829 |
| **2014 он** | 44.2 | 29.5 | 22.1 | 20.9 | 7859 | 366 |
| **2015 он** | 44.9 | 29.8 | 21.2 | 20.1 | 7806 | 512 |
| **2016 он** | 45.5 | 30 | 22.2 | 21.1 | 8043 | 519 |
| **2017 он** | 46.3 | 30.5 | 23.7 | 22.6 | 6812 | 633 |

2017 оны жилийн эцэст Ажиллах хүчний түүвэр судалгаагаар гаргасан үзүүлэлтүүдээр ажил эрхлэлтийн үзүүлэлтүүдийг тооцож харвал: Ажиллах хүчний идэвхийн ерөнхий коэффицент 51.1 болж өмнөх оноос 2.1 пунктээр өссөн нь нийт хүн амд эзлэх ажиллах хүчний тоо өсч 100 хүн тутмын 51 эдийн засгийн идэвхтэй хүн ам байгааг харуулж байна.

Эдийн засгийн ачаалал 28.7 болж 7.3 пунктээр буурсан үзүүлэлтэй байна. Энэ нь эдийн засгийн идэвхтэй 100 хүн тутмын 29 нь эдийн засгийн идэвхгүй буюу ажил идэвхтэй хайх сонирхолгүй иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна гэсэн үг юм. 2017 оны эцсийн байдлаар ЭЗИХА 6.8 хувиар өссөн, эдийн засгийн идэвхгүй хүн ам 15.3 хувиар буурсан зэрэг нь энэхүү үзүүлэлт 7.3 пунктээр буурахад нөлөөлжээ.

**Хүснэгт 2 Ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд /үргэлжлэл/**

| Ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд, оноор /үргэлжлэл/ | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Он** | **АХОТ** | **АХИЕК** | **ЭЗА** | **ХЭТ** | **Ат** | **ЭЗИБТ** |
| **2010 он** | 84.9 | 52.7 | 38.1 | 90.1 | 10.1 | 32.3 |
| **2011 он** | 83.8 | 54.2 | 30.6 | 91.4 | 8.8 | 25.6 |
| **2012 он** | 78.8 | 52.5 | 32.1 | 91.5 | 8.5 | 25.3 |
| **2013 он** | 72.7 | 48.6 | 42.9 | 93.5 | 6.3 | 31.2 |
| **2014 он** | 74.9 | 50.0 | 35.5 | 94.6 | 5.3 | 26.6 |
| **2015 он** | 73.1 | 47.2 | 36.8 | 94.8 | 5.5 | 26.2 |
| **2016 он** | 74.0 | 49.0 | 36 | 95.0 | 5.1 | 26.8 |
| **2017 он** | 77.7 | 51.1 | 28.7 | 95.4 | 4.4 | 22.3 |

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 95.4 болж өссөн нь эдийн засгийн идэвхтэй 100 хүн тутмын 95 нь ажиллагчид байгааг харууллаа. Энэхүү үзүүлэлт сүүлийн 5 жил тогтмол өсч байгаа нь дараах графикаас харагдаж байна.




**График 4 Ажиллах хүчний оролцооны түвшин 2010-2017 он /хувиар/**

Ажиллах хүчний оролцооны түвшин улсын дундажаар 61 байна. Дундговь аймгийн хувьд АХОТүвшин 77.7 болж өмнөх оноос 3.7 хувиар өссөн байна. Энэ нь хөдөлмөрийн насны 100 хүн тутмын 78 нь эдийн засгийн идэвхтэй хүн ам байна.

**График 5 Ажилгүйдлийн түвшин 2010-2017 он /хувиар/**



Ажилгүйдлийн түвшин 2017 оны эцсийн байдлаар 4.4 байгаа нь улсын дунджаас 2 дахин бага байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажилгүйдлийн түвшин 0.7 пунктээр буурсан байна.

**Хүснэгт 3 Ажил эрхлэлтийн үндсэн үзүүлэлт 2010-2017 он / Улсын дундажтай харьцуулсанаар/**

| Он | Ажиллах хүчний оролцооны түвшин /АХОТ/ | | Ажилгүйдлийн түвшин/АТ/ | |
|---|---|---|---|---|
| | Улс | Дундговь | Улс | Дундговь |
| **2010 он** | 61,6 | 84,9 | 9,9 | 10,1 |
| **2011 он** | 62,5 | 83,8 | 7,7 | 8,8 |
| **2012 он** | 63,5 | 78,8 | 8,2 | 8,5 |
| **2013 он** | 61,9 | 72,7 | 7,9 | 6,3 |
| **2014 он** | 62,1 | 74,9 | 7,9 | 5,2 |
| **2015 он** | 61,5 | 73,1 | 7,5 | 5,5 |
| **2016 он** | 60,5 | 74 | 10 | 5,1 |
| **2017 он** | 61 | 77,7 | 8,8 | 4,4 |

**График 6 Эдийн засгийн идэвхгүй байдлын түвшин /хувиар/**




Эдийн засгийн идэвхгүй хүн амтай холбоотойгоор эдийн засгийн идэвхгүй байдлын түвшин гэх үзүүлэлтийг тооцдог бөгөөд энэ нь хөдөлмөрийн насны хүн амд эзлэх эдийн засгийн идэвхгүй хүн амаар тодорхойлогдоно. Энэхүү үзүүлэлт 2017 оны байдлаар 22.3 болж өнгөрсөн оны мөн үеэс 4.5 пунктээр буурсан байна.

Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны 100 хүнд 22 эдийн засгийн идэвхгүй хүн ам ногдож байна гэсэн үг юм. Эдийн засгийн идэвхгүй байдлын түвшинг сүүлийн 7 жилээр дээрх графикт харууллаа.

## БҮЛЭГ 3. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТООН СУДАЛГААНЫ ДҮН

### 3.1 АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГААС АВСАН ТООН СУДАЛГААНЫ ДҮН

**График 7 Хуулийн этгээдийн өсөлт /тоо/**




2017 оны жилийн эцэст нийт 1075 ААН байгууллага татварын хэлтэст бүртгэлтэй байсан бол 2018 оны 4 дүгээр сард 1089 болж 14 аж ахуй нэгж буюу 1.3 хувиар өссөн байна.

**График 8 Нийт аж ахуй нэгж байгууллагын тоо, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо. 2018 оны 04 сарын байдлаар**




Нийт төсөвт байгууллагын 35.5%, ААН-ийн 4.2% нь LMIS програмд бүртгэлтэй байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээлийн lmis програмын ашиглалтыг сайжруулж, ААН байгууллагыг тогтмол бүртгэж хэвших шаардлагатай байгааг харуулж байна.

**График 9 Судалгаанд хамрагдсан аж ахуй нэгжийн тоо, сумдаар**



Судалгаанд 15 сумын 354 ААНБ хамрагдсанаас хамгийн их буюу 35.6 хувийг Сайнцагаан сум эзэлж байна.

**График 10 Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй ААН байгууллагын тоо, 2018 оны 4 сарын байдлаар судалгаанд хамрагдсан ААН байгууллагын тоо, хувь**




Судалгаанд ХХК-ны 49 хувь, хоршооны 42 хувь, ОНӨҮГ-ын 70 хувь, салбар нэгжийн /харилцаа холбоо, банк, ШТС г.м/ 19 хувь хамрагдсан байна. Үүнээс харахад судалгаанд хамрагдсан нийт ААН байгууллагын дийлэнх хувь нь хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

**График 11 Судалгаанд хамрагдсан ААН байгууллагуудын байгуулагдсан хугацаа /тоо, хувь/**




Судалгаанд хамрагдсан ААНбайгууллагын 146 буюу 41.2 хувь нь 2001-2010 онд байгуулагдсан, 154 буюу 43.5 хувь нь 2011-2018 онд байгуулагдсан ААН байгууллагууд байгаа нь үйл ажиллагаа тогтвортой болсныг илтгэж байна.

**График 12 Судалгаанд хамрагдсан ААН, байгууллагын ажилтны тоо, хүйс /тоо, хувь/**




Судалгаанд хамрагдсан ААН, байгууллагууд нийт 1637 ажилтантай, тэдгээрийн 1193 буюу 74 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь хөдөлмөрийн зах зээлд эрэгтэйчүүдийн оролцоо бага, эмэгтэйчүүд амьдрал ахуйгаа авч явах хандлага ихэссэнийг харуулж байна.

**Хүснэгт 4 Судалгаанд хамрагдсан ААНБ-н тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар, ажилтны тоо, хувь.**

| ААН байгууллагын эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар | Ажилтны тоо | | | | Нийт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | 1-9 | 10-19 | 20-49 | 50-99 | | |
| Хөдөө аж ахуйн, ойн аж ауй, загас барилт, ан агнуур | 53 | 2 | 0 | 0 | 55 | 16 |
| Уул уурхай олборлолт | 3 | 1 | 3 | 2 | 9 | 3 |
| Боловсруулах үйлдвэр | 13 | 0 | 0 | 0 | 13 | 4 |
| Цахилгаан, хий, уур, агааржуулалт | 0 | 0 | 0 | 2 | 2 | 1 |
| Барилга | 6 | 0 | 2 | 0 | 8 | 2 |
| Бөөний болон жижиглэн худалдаа | 142 | 4 | 2 | 0 | 148 | 42 |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 2 | 0 | 0 | 0 | 2 | 1 |
| Зочид буудал, байр, нийтийн хоолны үйлчилгээ | 18 | 4 | 2 | 0 | 24 | 7 |
| Мэдээлэл холбоо | 3 | 0 | 0 | 0 | 3 | 1 |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 30 | 1 | 2 | 0 | 33 | 9 |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 2 | 0 | 0 | 0 | 2 | 1 |
| Төрийн удирдлага батлан хамгаалах үйл ажиллагаа | 1 | 0 | 1 | 0 | 2 | 1 |
| Боловсрол | 2 | 0 | 0 | 0 | 2 | 1 |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа | 14 | 2 | 0 | 0 | 16 | 5 |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 26 | 2 | 1 | 0 | 29 | 8 |
| Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | 5 | 0 | 1 | 0 | 6 | 2 |
| Нийт | 320 | 16 | 14 | 4 | 354 | |
| Хувь | 90 | 5 | 4 | 1 | | |

Судалгаанд хамрагдсан 354 ААН байгууллагуудын 90 хувь нь 320 нь 1-9 ажилтантай жижиг ААН байгууллага байгаа бөгөөд эдгээрийн 142 буюу 44.3 % нь бөөний болон жижиглэн худалдаа, 18 нь буюу 5.6 % нь зочид буудал зоогийн газрын үйлчилгээ эрхэлж байхад, 13 ААНБ боловсруулах үйлдвэр эрхэлж байгаа нь хангалтгүй үзүүлэлт болж байна.

**График 13 ХАА-н салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо, хувь**




Хүснэгт 4-өөс харахад хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж буй 55 ААН байна. Эдгээрийг задлан харвал 31 буюу 56 хувь нь мал эмнэлгийн үйлчилгээ, 22 буюу 40 хувь нь газар тариалан мал аж ахуй, 4 хувь нь байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

**График 14 Судалгаанд хамрагдсан ААНБайгууллагуудын ажилтнуудын тоонд өөрчлөлт орсон байдал /сүүлийн 3 жилээр/ тоо, хувь**




Сүүлийн 3 жилийн байдлаар 18.6 хувь нь өөрчлөлт орж ажилтнууд нэмэгдсэн, 156 буюу 44.1

**График 15 Сүүлийн 3 жилд ажилтны тоонд өөрчлөлт орсон ААНБ-ын тоо, хувь, салбараар**

хувь нь өөрчлөлт гараагүй, 132 буюу 37.3 хувь нь хариулаагүй нь ажилтан тогтворгүй байх магадлалтай юм.




График 14-өөс сүүлийн 3 жилд ажилтны тоонд өөрчлөлт орсон ААНБ 66 байсан. Эдгээрийг салбараар авч үзэхэд 28 нь буюу 42% нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, зочид буудал зоогийн газрын үйлчилгээний салбарт 7 буюу 11 % нь үйл ажиллагаа явуулдаг ААНБ байна.

**График 16 Мэргэжил шаардах ажилд мэргэжлийн бус ажилтан ажиллуулж байгаа ААНБ-ын тоо, хувь**




Судалгаанд хамрагдсан ААН байгууллагын 8 хувь нь мэргэжил шаардах ажлын байранд мэргэжлийн бус ажилтан ажиллуулж байгаа нь мэргэжилтэй ажилтны нийлүүлэлт боломжийн байгааг харуулж байна.

**График 17 Хөдөлмөрийн зах зээл дээр зохих мэргэжлийн хүн олдоогүйгээс ажлын байрандаа ажилтан авч чадаагүй ААН байгууллага, мэргэжилээр, тоогоор**




График 17-оос харахад ААН байгууллагуудын 8 хувь нь хөдөлмөрийн зах зээл дээр мэргэжлийн хүн олдоогүй учир мэргэжил шаардсан ажлын байранд мэргэжлийн бус хүн ажиллуулж байна гэж хариулсан. Тэгвэл ААН байгууллагуудад **малын эмч**, **худалдагч касс, нярав**, нягтлан бодогч, тогооч, нарийн боовчин, ХММО, эм зүйч мэргэжилтэй ажилтан олдоц муутай байсан байна. Гэтэл судалгаанд хамрагдсан ажилгүй /хүснэгт 14/ нягтлан бодогч мэргэжилтэй 31 иргэн, худалдагч, касс, нярав мэргэжилтэй 22 иргэн байна. Хөдөлмөрийн зах зээл дээр бэлтгэгдсэн мэргэжилтэй ажилтан байсаар байтал ажил олгогч олддоггүй гэж хариулсан, мөн энэ чиглэлийн мэргэжилтэй ажилгүй иргэд ажил хайж байгаа нь ажил олгогч, ажилгүй иргэд мэдээлэл муутай, эдгээрийг холбох үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

**График 18 ААН байгууллагын ажилтнаа дахин сургах, мэргэшүүлэх шаардлагатай мэргэжил тоогоор**




Танай ААН ямар мэргэжлээр ажилтныг сургаж бэлтгэх, эсвэл мэргэжил ахиулах сонирхолтой вэ? гэсэн асуултад 142 ажил олгогч хариулсан бөгөөд тэдгээрийн дийлэнх нь нягтлан бодогч, тогооч, үйлчлэгч, мал эмнэлгийн техникч, туслах ажилтан, монтёруудаа мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, 13 ажил олгогч ажилтнууддаа харилцааны сургалтад хамруулах сонирхолтой гэж хариулжээ. Ажил олгогч мэргэжил шаардах ажлын байранд мэргэжлийн бус хүн ажиллуулахад тэдгээрийг зайлшгүй ажлын байранд дахин сургаж, мэргэшүүлэх хэрэгцээ байгааг илэрхийлж байна.

**График 19 Цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэх ААН байгууллага тоо, хувь**




**График 20 Өндөр насны тэтгэвэрт гарах ажилтны тоо**




Нийт 352 ААН байгууллагын 45 хувь нь цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэх сонирхол байгаа нь санхүү, эдийн засгийн болоод үйлдвэрлэл нэмэгдэх хандлагатай болж, үйл ажиллагаа нь тогтворжсон, 55 хувь нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх сонирхолгүй байна.

Судалгаанд хамрагдсан ААН, байгууллагад ажиллаж буй ажилтнуудын 11.8 хувь буюу 42 иргэн 2018-2020 онд тэтгэвэрт гарах, 82 хувь нь тэтгэвэрт гарах насны ажилтан байхгүй гэж хариулсан нь ААН байгууллага ажилтан сонгон шалгаруулж авахдаа насны хязгаар тогтоодогтой холбоотой залуу боловсон хүчинтэй байж болох юм.

**График 21 ААН байгууллагын үйл ажиллагаагаа өргөжүүлэх чиглэл тоо, хувь**




Бөөний болон жижиглэн худалдааны чиглэлээр 60 буюу 38 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр 28 буюу 17.7 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагааны чиглэлээр 20 буюу 12.7 хувь нь тус тус үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр төлөвлөж байна. Боловсруулах үйлдвэрлэл, ХАА болон үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа өргөжүүлэх ААНБ-ын тоо цөөн байгаа тул цаашид тэдгээрийг бодлогоор дэмжиж ажиллах хэрэгцээтэй нь харагдаж байна.

**График 22 Ажил олгогчдод ажилтан авахад тулгардаг бэрхшээл, хувь**




ААН байгууллага ажилтан авахад ажилд хандах хандлага төлөвшөөгүй байдаг 23 хувь, мэргэжлийн ур чадвар хангалтгүй 20 хувь, мэргэжлийн мэдлэг хангалтгүй 10 хувь 32 хувь, мэргэжлийн хүн олдохгүй, мэргэшсэн ажилтан хүрэлцээгүй гэж 7 хувь нь хариулсан байна.

Хандлага 23, ур чадвар 20, мэдлэг 10 нийт 53 чанартай холбоотой байна.

**График 23 Ажил олгогчийн ажилтанд тавьж буй шаардлага /тоо хувь/**




Ажил олгогчийн гол шалгуур нь ажилд хариуцлагатай хандах чадвар 26 хувь, ажлын ачаалал даах чадвар 21 хувь байна. Иймд ажилгүй, ажил хайж буй иргэдэд ажил олгогчийн тавьж буй ажилд хандах хандлага, ур чадварыг бий болгох хэрэгцээтэй байна.

**График 24** 2015-2018 онд их дээд сургууль, МСҮТ, коллеж төгсөгчдөөс ажилтнаар авч ажиллуулсан байдал /тоо, хувь/




Судалгаанд хамрагдсан ААНБ-ын 81.1 хувь нь их дээд сургууль, МСҮТ, коллеж төгсөгчдөөс ажилтанаар авч ажиллуулаагүй, 18.9 хувь нь ажилтан авч ажиллуулсан байгаа нь цаашид анхаарах асуудлын нэг юм.

**График 25 2015-2018 онд ААНБ-д ажилд орсон МСҮТ, коллеж төгсөгчдийн тоо /ажил мэргэжлээр/**




ААНБ-ын их дээд сургууль, МСҮТ, коллеж төгсөгчдөөс ажилд авсан байдлыг мэргэжлийн ангилалаар авч үзвэл нягтлан бодогч, инженер, тогооч, нарийн боовчин мэргэжлээр ихэвчлэн ажилд авдаг нь харагдаж байна.

**Хүснэгт 5** Судалгаанд хамрагдсан ААНБ-ын тоо, шинээр авсан ажилтанд олгодог цалингийн хэмжээгээр

| Цалингийн шатлал | Инженер техникийн ажилтан | Албан хаагч | Үндсэн үйлдвэрлэл үйлчилгээний мэргэжлийн ажилтан | Туслах үйлдвэрлэл үйлчилгээний мэргэжлийн ажилтан | Түр ба улирлын ажилтан | Мэргэжил боловсрол шаардахгүй энгийн ажилтан | Нийт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 192001-250000 | 12 | 24 | 60 | 34 | 27 | 30 | 187 | 44,1 |
| 250001-450000 | 4 | 16 | 55 | 28 | 10 | 10 | 123 | 29 |
| 450001-650000 | 7 | 13 | 34 | 7 | 3 | 6 | 70 | 16,5 |
| 650001-850000 | 9 | 10 | 3 | 3 | 4 | 3 | 32 | 7,55 |
| 850001-ээс дээш | 10 | 1 | 0 | 1 | 0 | 0 | 12 | 2,83 |

ААНБ-д мэргэжлээрээ анх ажилласан хүмүүсийн сарын үндсэн цалингийн шатлалыг харвал үндсэн үйлдвэрлэл үйлчилгээний мэргэжлийн ажилтан дийлэнх нь буюу 192000-450000 төгрөгийн цалингаар цалинждаг гэж харагдаж байна. Үндсэн үйлдвэрлэл үйлчилгээний мэргэжлийн ажилтан 192000-450000 төгрөгөөр цалинжуулдаг ААНБ-ыг салбараар авч үзье.

**График 26 Үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээний мэргэжлийн ажилтан шинээр авахад 192001-450000 төгрөгөөр ААНБ тоо, хувь, салбараар**




Дээрх хүснэгтэд харуулсанаар шинээр ажилд орсон ажилтанд 192001-250000 цалин олгодог 60, 250001-450000 цалин олгодог 55 ААНБ байгаа нь нийт хариултын 72%-ийг эзэлж байгаа нь шинэ ажилтны цалин бага байдаг гэсэн дүгнэлтэд хүргэж байна

**График 27 Судалгаанд хамрагдсан ААН байгууллага сүүлийн 3 жилд ажилтнаа сургалтанд хамруулсан эсэх тоо, хувь**




Сүүлийн 3 жилийн байдлаар судалгаанд хамрагдсан ААНБайгууллагын 33.9 хувь нь ажилтнуудаа сургалтанд хамруулсан байгаагаас харахад ажил олгогч ажилтнаа чадавхжуулах сургалтанд хамруулах хэрэгцээтэй байгаа боловч ААНБайгууллагууд ажилтнаа сургалтанд хамруулах сонирхолгүй байгаа нь графикаас харагдаж байна. Иймд ААНБайгууллагуудын удирдлагуудыг чадвахжуулах, мэдээллээр ханган, хамтран ажиллах шаардлагатай байна.

**График 28 Ажилтнаа сургалтад хамруулсан ААНБ тоо, хувь**




ААН байгууллага нь нийт ажилтны 15.6 хувийг мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын сургалтад, 7.3 хувь нь үйлдвэр дээрх мэргэжил олгох сургалтад хамруулж байгаа нь хангалтгүй байгаа тул ажил олгогч, сургалтын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна. ААНБ ажилтнаа сургах сонирхолгүй байдаг нь ажил олгогч ажилтнаа ойр ойр солих, шинэ ажилтан авч байгаа үзүүлэлтэд нөлөөлж болох юм.

**График 29 Ажил олгогч ажилтнаа сургахад тулгарч буй бэрхшээл**




Судалгаанд хамрагдсан ААНБ-ын 35 хувь нь сургалтын өртөг өндөр, 20 хувь нь мэдээлэл дутмаг, 16 хувь нь үйлдвэрлэл дээрх сургалт явуулах боломж хомс, 13 хувь нь сургалтын байгууллагын сургалтын чанар муу, 12 хувь нь сургалтын байгууллага байхгүй гэж хариулсан байна. Энэ нь орон нутгийн чадавхтай сургалтын байгууллагыг дэмжиж хамтран ажиллах, сургалтын байгууллага бий болгох шаардлагтай байгааг харуулж байна.

**График 30 Таны эрхэлж буй үйлдвэрлэлийн хөгжилд дараах ур чадвараас аль нь илүү нөлөөлж байна вэ? асуултад хариулсан байдал, хувь**




Үйлдвэрлэлийн хөгжилд 24% нь санхүүгийн менежментийн ур чадвар, 21% нь удирдлагын ур чадвар, 17% нь маркетингийн ур чадвар чухал гэж хариулснаас харахад ажил олгогчдод дээрх чиглэлийн сургалт хэрэгцээтэй байгааг харуулж байна.

**Хүснэгт 6 Ойрын 3 жилд ямар мэргэжлээр хичнээн ажлын байр бий болохыг хүснэгтээр харуулав**

| Салбар | Эзэмшсэн мэргэжил | Үсгэн код | Индекс | Ажил олгогч | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2018 | 2019 | 2020 |
| 1.Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур /тариаланч, ногоочин, малчин, амьтан маллагч, газар тариаланч, фермч / | Мал амьтныг вакцинжуулагч | | 3240-14 | 1 | | |
| | Агротехникч | | 3142-13 | 1 | | |
| | Цэцэрлэгч, цэцэрлэгт хүрээлэнгийн | | 6113-16 | 1 | | |
| | | | | **3** | **0** | **0** |
| 2.Уул уурхай, олборлолт /Бичил уурхай/ | Геологич | MG | 2114-11 | 2 | | |
| | Өрмийн мастер, туслах | MR | 8111-25 | 1 | | |
| | Инженер, баяжуулахын | | 2146-11 | 1 | | |
| | Хүнд машин механизмын оператор | MT | 8111-35 | 31 | 30 | 40 |
| | Механикч инженер | | 2144-35 | 1 | | |
| | | | | **36** | **30** | **40** |
| 3.Боловсруулах үйлдвэр/Блок,тоосго, модон эдлэл, ноос, арьс ширээр үйлдвэрлэгч/ | Мужаан | CF | 7115-24 | | 2 | |
| | | | | **0** | **2** | **0** |
| 4.Цахилгаан, хий, уур, агааржуулалт/гагнуурын үйл ажиллагаа/ | Цахилгаанчин | CF | 7411-12 | 1 | | |
| | цахилгааны инженер | PL | 2151-11 | 12 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | **13** | **0** | **0** |
| 6.Барилга /Барилгачин, өрөгч, хэв цутгагч г.мэт/ | Барилгын Өрөг угсрагч | CF | 7112-11 | 12 | 1 | |
| | Барилгын техникч | CF | 3112-11 | 1 | | |
| | Барилгын материал үйлдвэрлэлийн техникч | | 3112-14 | 1 | | |
| | Бетон арматурчин | CF | 7114-20 | 2 | | |
| | Шаварчин, засал чимэглэлчин | CF | 7123-20 | | 5 | |
| | Туслах ажилтан | | 9312-11 | 13 | | 5 |
| | | | | **29** | **6** | **5** |
| 7.Бөөний болон жижиглэн худалдаа: /Машин болон мотоциклын засвар,дугуй засвар / | Автомашины засварчин | TC | 8211-20 | 5 | 3 | |
| | Худалдааны менежер | SO | 1420-12 | 3 | 1 | |
| | Борлуулалтын менежер | BT | 5242-13 | 1 | | |
| | Худалдагч | BT | 5223-15 | 13 | 2 | 2 |
| | Туслах ажилтан | | 9629-15 | 23 | | 1 |
| | | | | **45** | **6** | **2** |
| 8.Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа/ачаа болон хүн тээврийн үйлчилгээ / | Жолооч | TC | 8331-14 | 4 | | |
| | | | | **4** | **0** | **0** |
| 9.Зочид буудал, байр, нийтийн хоолны үйлчилгээ /Хоол үйлдвэрлэл, караоке бар/ | Зөөгч, бармен | IF | 5131-11 | 1 | | |
| | Тогооч | IF | 5120-11 | 12 | 1 | 1 |
| | Хоол үйлдвэрлэл Технологич | IF | 3434-14 | | | |
| | Зочид буудал, зоогийн газрын туслах ажилтан | | 2411 | 19 | | |
| | Сүү боловсруулах үйлдвэрийн ажилтан | | 7213-23 | 1 | | |
| | Зочид буудлын менежер | BT | 3339-11 | 3 | | |
| | Хүнсний эрүүл ахуйч | HO | 2265-13 | 9 | | |
| | | | | **45** | **1** | **1** |
| 10. Мэдээлэл холбоо | Дүрслэх урлаг, график | IT | 3512-15 | | 1 | |
| | Компьютерийн операторчин, техник хангамж | IO | 4120-13 | 2 | 1 | |
| | | | | **2** | **2** | **0** |
| 11.Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | Банк, санхүү | BF | 4312 | 1 | | |
| | Нягтлан бодогч | BF | | 14 | 1 | |
| | Нярав | BT | 4321-17 | 3 | | |
| | | | | **18** | **1** | **0** |
| 14.Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | ХАБЭА-н улсын байцаагч | MG | 3118-14 | 3 | | |
| | | | | **3** | **0** | **0** |
| 18. Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа/эх баригч, сувилахуйн мэргэжилтэн, эмийн сан, малын эмч/ | Бариа засалч | HO | 3230-11 | 1 | | |
| | Их эмч, бага эмч | HO | 2211-11 | 1 | | |
| | Малын эмч, мал зүйч, зоо техникч | AT | 2250-22 | 17 | 1 | |
| | Сувилагч | HO | 3256-14 | 2 | 1 | 1 |
| | Эх баригч | | 2222-11 | 1 | | |
| | Шүдний техникч | | 3214-11 | 7 | | |
| | Эм зүйч | HO | 2262-11 | 3 | 2 | |
| | | | | **32** | **4** | **1** |
| 20. Үйлчилгээний бусад үйл ажиллагаа/алт мөнгөний дархан, үсчин гоо сайханч,оёдол, эсгий сүлжмэл эдлэл, талх нарийн боов/ | Нарийн боовчин | IF | 7512-34 | 4 | 1 | 1 |
| | Оёдолчин, зөөлөн эдлэлийн | IE | 7533-28 | 2 | 3 | |
| | Шатахуун түгээгч | MF | 5245-12 | 2 | | |
| | Лам | | 2636-29 | | 2 | |
| | Сургагч багш | | | 2 | | |
| | | | | **10** | **6** | **2** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 21 Олон улсын байгууллага суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | Аялал жуулчлалын менежер | | 1438-15 | 1 | | |
| | | | | 1 | 0 | 0 |
| Нийт дүн | | | | 241 | 58 | 51 |

ААНБ-уудад шинээр бий болох ажлын байрыг судлахад ойрын 3 жилд нийт 350 ажлын байранд шинээр ажилтан авах буюу 2018 онд бөөний болон жижиглэн худалдааны салбарт 45, зочид буудал байр, нийтийн хоолны салбарт 45, уул уурхайн салбарт 36 ажлын байр бий болохоор харагдаж байна.

**График 31 ААН байгууллагууд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагатай хамтран ажиллах сонирхолтой эсэх, тоогоор**




Судалгаанд хамрагдсан ААН байгууллагууд МСҮТ-тэй хамтран мэргэжлийн зэрэг ахиулах, давтан сургалтад хамруулах сонирхол давамгайлж байна.

**График 32 МСҮТ-тэй хамтран ажилтнуудынхаа мэргэжлийн зэргийг ахиулах хүсэлтэй ААН байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл, тоогоор**



Бөөний болон жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААН байгууллага ажилтнуудынхаа мэргэжлийн зэргийг ахиулах, мэргэшүүлэх сонирхол их байгаа нь графикаас харагдаж байна.

Энэ удаагийн судалгаанд төсвийн байгууллага хамрагдаагүй тул зарим мэргэжлийн эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлох боломжгүй байсан. Цаашид төсвийн байгууллагыг хамруулах шаардлагатай

## 3.2 ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДЭЭС АВСАН ТООН СУДАЛГААНЫ ДҮН

Дундговь аймгийн 15 сумын 718 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн 436 буюу 60.7 хувь нь судалгаанд хамрагдсан. Сайнцагаан сумын ХХЭрхлэгчдийн 34.2 хувийг, бусад сумдын ХХЭрхлэгчдийг 100 хувь хамруулсан.

**График 33 Судалгаанд хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгчид, сумдаар /Тоо, хувь/**




Судалгаанд ХХЭ-ийн 35.9 хувь буюу 157 нь Сайнцагаан сум, 10.8 хувь 47 нь Говь-Угтаал сум, 9.4 хувь буюу 41 нь Эрдэнэдалай сумаас хамгийн их хамрагдсан байна.

**График 34 ХХЭ-н тоо, насны ангиллаар**




**График 35 Судалгаанд хамрагдсан ХХЭ-н боловсролын түвшин**




Судалгаанд хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн 44.7 хувь нь эрэгтэй, 55.3 хувь нь эмэгтэй, насны бүлгээр авч үзвэл дийлэнх буюу 53.8 хувийг 36-55 насны иргэд, хамгийн бага буюу 3.6 хувийг 15-25 насны иргэд эзэлж байна. /График 33/

Судалгаанд хамрагдсан иргэдийг боловсролын түвшингээр харвал хамгийн их буюу 45.8 хувь нь бүрэн дунд боловсролтой, 15,1 хувь нь мэргэжлийн боловсролтой, 13,5 хувь нь суурь боловсролтой иргэд байна. Үүнээс үзэхэд 36-55 насны бүрэн дунд боловсролтой иргэд хувиараа хөдөлмөр эрхэлж байна.

**График 36 Дундговь аймгийн хүн амд ХХЭ иргэдийн эзлэх хувь, насны ангиллаар**



| Насны ангилал | Хүн амын тоо | Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо | Хүн амд ХХЭ-н эзлэх хувь |
|---|---|---|---|
| 15-25 | 8747 | 16 | 0.2 |
| 26-35 | 7386 | 84 | 1.1 |
| 36-45 | 6344 | 117 | 1.8 |
| 46-55 | 5079 | 118 | 2.3 |
| 56-60 | 1944 | 61 | 3.1 |
| 61-65 | 1236 | 40 | 3.2 |

## Эдийн засгийн үйл ажиллагааны салбар:

**График 37 Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбар**




Судалгаанд хамрагдсан нийт 436 ХХЭ-ийн 65% нь үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт, 46 нь буюу 10.6 % нь бөөний болон жижиглэн худалдаа эрхэлж байгаа нь эерэг үзүүлэлт юм. Иймд ХХЭ-ийг бодлогоор дэмжиж, үйл ажиллагааг нь өргөжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

**График 38 ХХЭ-н тоо, үйл ажиллагаа эрхэлсэн хугацаа насны бүлгээр**







36-с дээш насны иргэд 5-с дээш жил үйл ажиллагаа эрхэлж буй нь нас тогтсон иргэдийн хувьд үйл ажиллагаа тогтворжсон, 35-с доош насны залуучуудын хувьд аж ахуй шинээр эхэлж буйг илтгэж байна.

Санхүүгийн эх үүсвэрийн хувьд хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн 45 хувь нь өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа эхэлсэн. 50 хувь нь банкны зээл, төсөл хөтөлбөрөөр санхүүжилт авсан нь төсөл, хөтөлбөр, банкны зээлийн талаар иргэдийн мэдээлэл сайн, зохих хэмжээнд хамрагдаж буйг харуулж байна.

**График 40 ААН, ХХЭрхлэгч иргэдийн үйл ажиллагааны чиглэлийг харьцуулж үзүүлбэл**




ААН нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, ХАА-н салбарт, хувиараа хөдөлмөр эрхлэгчид нь үйлчилгээний болон боловсруулах үйлдвэрийн салбарт голчлон үйл ажиллагаа явуулж байна. Харин хувиараа хөдөлмөр эрхлэгчид үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа нь дээрх графикаас харагдаж байна

**График 41 Хувиараа хөдөлмөр эрхлэгчид ажилтан ажиллуулдаг эсэх**

Судалгаанд хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхэлгчдийн 77 хувь буюу 336 нь ажилтантай гэж хариулсан. 100 ХХЭ өөрөө өөртөө ажил олгогч юм.




**График 42 Ажилтнаа цалинжуулдаг ХХЭ-н тоо, хувь, ажилтны тоогоор**



Цалин олгож ажилтан ажиллуулж буй 131 хувиараа хөдөлмөр эрхлэгч байна. Үүнээс 67 буюу 51.1 хувь нь 1 ажилтантай, 41 буюу 31.3 хувь нь 2-3 ажилтантай, 12 буюу 9.2 хувь нь 4-5 ажилтантайгаар үйл ажиллагаа эрхэлж байна.

**График 43 Цалин хөлсгүй ажилтан ажиллуулж буй ХХЭ-н тоо, ажилтны тоогоор**




Цалин хөлсгүйгээр ажилтан ажиллуулж буй 205 хувиараа хөдөлмөр эрхлэгч байгаа нь өрхийн үйлдвэрлэлд гэр бүл, ойр дотны иргэдийг цалин хөлсгүйгээр ажиллуулдаг байх магадлалтай юм. Цалин хөлсгүй 1 ажилтантай ХХЭ 108 буюу 24.7 хувь, 2 ажилтантай ХХЭ 69 буюу 15.8 хувь байна.

**График 44 Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажилтандаа өгч буй дундаж цалингийн хэмжээ /тоо, хувь/**




Цалинтай ажилтан ажиллуулдаг хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 75 буюу 57.3 хувь нь 300 мянга хүртэл төгрөгийн цалин, 5 буюу 3.8 хувь нь 450 мянган төгрөгөөс дээш цалин олгодог байна. 20 хувиараа хөдөлмөр эрхлэгч цалингийн хэмжээг хэлэхээс татгалзсан байна.

**График 45 ХХЭ-н тоо, цалингийн хэмжээ, үйл ажиллагааны салбараар**



Дээрх графикаас цалин олгож буй ХХЭ-ийн 67.5 хувь нь 300000 хүртэл төгрөгийн дундаж цалинг олгодог ба үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ХХЭ 43 буюу 38.7 хувийг эзэлж байна.

**График 46 ХХЭ-н тоо, ажилтан халсан эсэх**




**График 47 ХХЭ-н тоо, ажилтан ажлаас халсан шалтгаан**




Судалгаанд хамрагдсан ХХЭ-н 13.7 хувь буюу 60 нь ажилтан ажлаас халж байсан ба ажлаас халсан шалтгааны 86.6 хувьд ажилтан өөрийн хүсэлтээр халагдаж байсан байна.

**График 48 Ажилтан ажлаас халсан ХХЭ-н тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар**




Ажилтан ажлаас халсан ХХЭ-н тоог эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд хамгийн өндөр 36.7 хувь буюу 22 нь “Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар”-т

үйл ажиллагаа явуулж буй ХХЭ, 26.7 хувь буюу 16 нь “Зочид буудал, байр нийтийн хоолны үйлчилгээний салбар”-т үйл ажиллагаа явуулж буй хувиараа хөдөлмөр эрхлэгчид байна. Зочид буудал, байр, нийтийн хоолны үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй ХХЭ иргэд /График 47/ ажилтнаа тогтвортой ажиллуулж чадахгүй байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 14.7 хувь нь буюу 64 нь ажилтнаа тогтвор суурьшилтай ажиллуулах тал дээр зохих арга хэмжээг авч ажилсан бол 11.2 хувь буюу 49 нь ямар нэг ажил төлөвлөөгүй байна. 223 нь хариулаагүй байна.

**График 49 ХХЭ иргэд эрхэлж буй үйл ажиллагааг өргөжүүлэх өмчийн хэлбэр тоо, хувь**




436 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнээс 179 нь ААН болж өргөжих хүсэлтэй гэж хариулсан. Үүнээс 114 ХХЭ нөхөрлөл, хоршоо болохыг хүссэн нь иргэд хамтын аж ахуй эрхлэх сонирхолтойг илэрхийлсэн байна. Иймд нөхөрлөл, хоршооны чиглэлээр ХХЭ иргэдэд мэдээлэл хүргэх, албан бус сектороос албан секторт шилжихэд нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй нь харагдаж байна.

**График 50 ААН болж өргөжихгүй байгаа шалтгаан**



| Ажилтнаа тогтвортой ажиллуулах | Тоо | Хувь |
|---|---|---|
| Нийгмийн асуудлыг шийдсэн | 14 | 3.2 % |
| Цалин урамшууллыг нэмсэн | 16 | 3.7% |
| Сургалтад хамруулсан | 34 | 7.8% |
| Ямар нэг ажил хийж амжаагүй | 49 | 11.2% |
| Харилаагүй | 223 | 51.1% |
| Ажилтангүй | 100 | 22.9% |




ААН болж өргөжихгүй 257 ХХЭ-ийн 57.6 хувь нь шаардлагагүй, 26.5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэх нь хялбар, 8.2 хувь нь ААН болох мэдлэг дутмаг гэж хариулсан ба энэ нь хувиараа хөдөлмөр эрхлэх нь тэдэнд хялбар байдгийг харуулахын зэрэгцээ ААН болохын ашиг тус, албан секторт шилжих, хариуцлагын хэлбэрийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгааг илэрхийлж байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 69 хувь нь цаашид ажилтан авахгүй, мөн албан секторт 59 хувь нь шилжихгүй гэж хариулж байгаагийн шалтгаан нь үйл ажиллагааны ашиг, алдагдалтай хамааралтай байх магадлалтай.

**График 51 Цаашид ажилтан авах эсэх**




**График 52 Ажилтан авахад харгалзах ур чадвар**




Судалгаанд хамрагдсан ХХЭ-н 31 хувь буюу 137 нь шинээр ажилтан авна, 69 хувь буюу 229 нь ажилтан авахгүй гэж хариулсан. Ажилтан авах хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 36.4 хувь нь ажилд хариуцлагатай хандах хандлагыг, 15.3 хувь нь ажлын ачаалал даах чадварыг, 33.5 хувь нь дээрх ур чадваруудыг бүгдийг харна гэсэн байна.

**Хүснэгт 7 2018-2020 онд шинээр авах ажилтны тоог салбараар ангилахад:**

| Салбар | Эзэмшсэн мэргэжил | Үсгэн код | Индекс | ХХЭрхлэгч | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2018 | 2019 | 2020 |
| 1. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт,ан агнуур/тариаланч, ногоочин, малчин, | Жимс ногооны мэргэжилтэн | AF | 6112-13 | 1 | 3 | |
| | Уламжлалт мал аж ахуйн фермер/туслах малчин | | 6320-14 | 25 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| амьтан маллагч, газар тариаланч, фермч / | | | | | | |
| | | | | **26** | **3** | **0** |
| 3.Боловсруулах үйлдвэр /Блок,тоосго, модон эдлэл, ноос, арьс ширээр үйлдвэрлэгч/ | Мужаан | CF | 7115-24 | 11 | 1 | |
| | Сийлбэрчин | AM | 7313-28 | 1 | | |
| | Сүлжигч | IE | 8152-33 | 1 | | |
| | | | | **13** | **1** | **0** |
| 4. Цахилгаан, хий, уур, агааржуулалт /гагнуурын үйл ажиллагаа/ | Гагнуурчин | IM | 7212-14 | 3 | 1 | |
| | | | | **3** | **1** | **0** |
| 6. Барилга /Барилгачин, өрөгч, хэв цутгагч г.мэт/ | Туслах ажилтан | | | 2 | | |
| | | | | **2** | **0** | **0** |
| 7.Бөөний болон жижиглэн худалдаа: /Машин болон мотоциклын засвар,дугуй засвар / | Автомашины засварчин | TC | 8211-20 | 2 | 2 | |
| | Дугуй завсарчин | TC | 8211-20 | 4 | | |
| | Худалдагч | BT | 5223-15 | 10 | | |
| | | | | **16** | **2** | **0** |
| 8.Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа/ачаа болон хүн тээврийн үйлчилгээ / | Жолооч | TC | 8331-14 | 1 | | |
| | Туслах ажилтан | | | 1 | | |
| | | | | **2** | **0** | **0** |
| 9. Зочид буудал, байр,нийтийн хоолны үйлчилгээ /Хоол үйлдвэрлэл, караоке бар/ | Зөөгч, бармен | IF | 5131-11 | 2 | 4 | |
| | Тогооч | IF | 5120-11 | 26 | 3 | |
| | Зочид буудал, зоогийн газрын туслах ажилтан | | 2411 | 6 | | |
| | Хүнсний эрүүл ахуйч | HO | 2265-13 | | 1 | |
| | | | | **34** | **8** | **0** |
| 10. Мэдээлэл холбоо | Компьютер, Программ хангамжын инженер | IT | 2512-16 | 1 | 1 | |
| | Эх бэлтгэгч | | 7323 | 1 | | |
| | Туслах ажилтан | | | 1 | | |
| | | | | **3** | **1** | **0** |
| 11.Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | Нягтлан бодогч | BF | | 5 | | |
| | | | | **5** | **0** | **0** |
| 18. Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа /эх баригч, сувилахуйн мэргэжилтэн, эмийн сан, малын эмч/ | Малын эмч, мал зүйч, зоо техникч | AT | 2250-22 | 1 | | |
| | Сувилагч | HO | 3256-14 | 1 | | |
| | | | | **2** | **0** | **0** |
| 20. Үйлчилгээний бусад үйл ажиллагаа /алт мөнгөний дархан, үсчин гоо сайханч,оёдол, эсгий сүлжмэл эдлэл, талх нарийн боов/ | Гар урлал | AM | 7319 | 3 | | |
| | Гоо сайханч, холбогдох бусад ажилтан | SO | 5142-11 | 12 | 5 | 1 |
| | Гуталчны туслах ажилтан | | | 1 | | |
| | Гуталчин | SO | 7536-22 | 3 | | |
| | Нарийн боовчин | IF | 7512-34 | 3 | 2 | |
| | Оёдолчин, зөөлөн эдлэлийн | IE | 7533-28 | 13 | 3 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Үйлчлэгч | | 9112 | 2 | | |
| | Үсчин | SO | 5141-11 | 5 | 1 | |
| | | | | **42** | **11** | **1** |
| 21. Мэргэжилгүй | | | | | 4 | |
| **Нийт дүн** | | | | 148 | 27 | 1 |

Зочид буудал, байр, нийтийн хоолны салбарт 34, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 42, ХАА салбарт 26 ажилтан авах хэрэгцээтэй харагдаж байна.

**График 53 Аж ахуй эрхлэлтийн сургалтын хэрэгцээг судлахад:**

Судалгаанд хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 43 хувь нь сургалтын хэрэгцээгүй гэж 57 хувь буюу 249 нь аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдах хүсэлтэйгээ илэрхийлсэн.

Иймд хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд дээрх судалгаануудад үндэслэн хэрэгцээт аж ахуй эрхлэлтийн сургалтуудыг зохион байгуулах хэрэгтэй байна.




## ДҮГНЭЛТ

Судалгаанд хамрагдсан 436 ХХЭ-ийн 35.9 хувь нь Сайнцагаан сумаас хамрагдсан байна. ХХЭ-н 45.8% нь бүрэн дунд боловсролтой, 36-55 насны иргэд 44.7%-г эзэлж, “Үйлчилгээний бусад үйл ажиллагаа”-ны салбарт 41.5%, “Боловсруулах үйлдвэрийн салбар”-т 12.2% нь үйл ажиллагаа явуулдаг ба аймгийн хүн амд ХХЭ-н эзлэх хувь 5.59% байна.

ХХЭ иргэдийн 59.1% нь 5 дээш жил, 16.5% нь 4-5 жил, 15.8% нь 2-3 жил, 8.4% нь 1 жилээс доош хугацаагаар үйл ажиллагаа эрхэлж байна.

Цалинтай ажилтан ажиллуулдаг хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 75 буюу 57.3 хувь нь 300 мянга хүртэл төгрөгийн цалин, 5 буюу 3.8 хувь нь 450 мянган төгрөгөөс дээш цалин олгодог байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд ажилтнууддаа бага цалин олгодог нь харагдаж байна.

Судалгаанаас үзэхэд ААН болж өргөжихгүй 257 ХХЭ-ийн 57.5% нь шаардлагагүй, 26.4% нь хувиараа хөдөлмөр эрхлэх нь хялбар, 8.1% нь ААН болох мэдлэг дутмаг гэж хариулсан ба энэ нь хувиараа хөдөлмөр эрхлэх нь тэдэнд хялбар байдгийг харуулахын зэрэгцээ ААН болохын ашиг тус, албан секторт шилжих, хариуцлагын хэлбэрийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгааг илэрхийлж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр ХХЭ нь үйлчилгээний болон, боловсруулах үйлдвэрийн салбарт түлхүү хөгжиж, ААН болохыг хүссэн ХХЭ-ийн 114 нь нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуйгаа өргөжүүлэх хүсэлтэй байгаа нь сайшаалтай. Иймд өргөжих хүсэлтэй ХХЭ-ийг бодлогоор дэмжин өргөжүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

## 3.3 МАЛЧин өрхөөс АВСАН тоон СУДАЛГААНЫ ДҮН

**График 54 Судалгаанд хамрагдсан малчин өрхийн хувь, сумдаар**




**Хүснэгт 8 Судалгаанд хамрагдсан малчин өрхийн тоо, сумдаар**

| Сум | Сайнцагаан | Адаацаг | Баянжаргалан | Говь-Угтаал | Гурвансайхан | Дэлгэрхангай | Дэлгэрцогт | Дэрэн | Луус | Өлзийт | Өндөршил | Сайхан-Овоо | Хулд | Цагаандэлгэр | Эрдэнэдалай | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Өрхийн тоо | 86 | 51 | 24 | 30 | 61 | 42 | 34 | 41 | 34 | 43 | 25 | 42 | 45 | 26 | 126 | **710** |

Малын тоо болон, малчин өрхийн тоогоор Эрдэнэдалай, Сайнцагаан, Гурвансайхан сумын малчид судалгаанд оролцогчдын 39% буюу дийлэнх хувийг бүрдүүлсэн байна.

**График 55 Өрхийн тэргүүлэгчийн нас, хүйсийн суварга /хувь, тоо/**




Малчин өрхөд 36-аас дээш насны малчид 70-аас дээш хувийг, 15-35 насны залуу малчид 23 хувийг эзэлж байгаа нь мал аж ахуйн салбарт ажиллах залуу малчдыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Өрхийн тэргүүлэгчийн 92%-ийг эрэгтэйчүүд эзэлж байна.

**График 56 Аймгийн нийт 8283 малтай өрхийн тоо, судалгаанд хамрагдсан 710 малчин өрхийн тооны харьцуулалт, малын тоо, хувиар**




**Малчин өрхийн тоо, малын тоогоор**

| | Малчин өрхийн малын бүлэглэлт /тоо/ | | | |
|---|---|---|---|---|
| | **200 хүртэл** | **201-500** | **501-999** | **1000-аас дээш** |
| Аймгийн хэмжээнд /2017 он/ | 1882 | 2547 | 1784 | 788 |
| Түүвэр судалгаагаар | 157 | 261 | 175 | 106 |

Дээрх зургаас харахад түүвэр судалгаанд хамрагдсан малчин өрхийн малын тоо нь аймгийн нийт малтай өрхийн тоог малын тооны бүлэглэлээр харьцуулахад ойролцоо байгаа нь түүвэрлэлт эх олонлогийг төлөөлж чадаж байгааг харуулж байна. Судалгаанд 1000-аас дээш малтай малчин өрх харьцангуйгаар илүү хамрагдсан байгаа нь туслах малчдын хэрэгцээг тодорхойлох зорилгод нийцэж байна. Дунджаар 201-1000 малтай өрх 60 гаруй хувийг эзэлж байна.

**График 57 Малчин өрхийн тэргүүлэгчдийн насыг боловсролын түвшинтэй харьцуулсан үзүүлэлт, хувь**




Судалгаанд хамрагдсан малчин өрхийн тэргүүлэгчдийн 93 хувь нь бага, суурь, бүрэн дунд боловсролтой байна. 61-ээс дээш настай малчдын 60 хувь бага боловсролтой байна. Харин 36-60 насныхны хувьд суурь боловсролтой малчны эзлэх хувь өндөр байна. Энэ нь нэгдэлжих хөдөлгөөний үед 8-р анги төгсөгчид илгээлтээр мал аж ахуйн салбарт гарч байсантай холбоотой байх боломжтой. 1983-1992 онд төрсөн малчдын дунд бага боловсрол эзэмшигчдийн эзлэх хувь их байгаа нь өмч хувьчлал, нийгмийн шилжилттэй холбоотой байж болох юм. 1992-2003 онд төрсөн малчдын хувьд дээд, техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшигчдийн эзлэх хувь тодорхой хувиар нэмэгдэж байгаа нь иргэдийн хөдөө рүү чиглэсэн эерэг хандлага бий болж эхэлж байгааг харуулж байна.

**График 58 Өрхийн мал аж ахуйн үйлдвэрлэлд оролцогчид буюу нийт малчдын хүйсийн тоон харьцаа /өрхийн тэргүүлэгчийн тоо орсон/**




Мал аж ахуйн үйлдвэрлэлд оролцогчдыг хүйсээр харвал 67 хувь нь эрэгтэй, 33 хувь нь эмэгтэй байна. Үүнээс харахад мал аж ахуйн үйлдвэрлэлд эмэгтэйчүүд бага оролцож байгаа нь харагдаж байна.

**График 59 Малчин өрхийн тоо, өрхийн тэргүүний насны ангиллаар**




Малчин өрхийн үйлдвэрлэлд 35-60 насны малчдын тоо ихэнх хувийг эзэлж байгаа ба залуу малчдын эзлэх хувь бага байгаа нь цаашид залуу малчдыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

**График 60 Аймгийн нийт малчдын тоо судалгаанд хамрагдсан малчдын тооны харьцуулалт**




Судалгаанд хамрагдсан 710 малчин өрхийн 41.2 хувь буюу 293 малчин нийгмийн даатгалд хамрагдсан бол 58.8 хувь буюу 417 нь хамрагдаагүй байна.

**График 61 Судалгаанд хамрагдсан малчин өрхийн тэргүүлэгчийн нийгмийн даатгалд хамрагдсан байдал, насны бүлэг, хувиар**



**График 62 Туслах малчинтай өрх /хувь**




**График 63 Туслах малчин авах хэрэгцээ /хувь, тоо**




Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 93.9 хувь туслах малчингүй, 6.1 хувь нь туслах малчинтай байгаа бөгөөд туслах малчингүй хэсэг дийлэнх хувийг эзэлж байна. Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 22% нь туслах малчин авах шаардлагатай гэж хариулжээ.

**График 64 Туслах малчин авах хэрэгцээтэй өрхийн тоо, сумдаар**




Эрдэнэдалай, Сайнцагаан, Хулд, Говь-Угтаал, Луус сумдад туслах малчин авах хэрэгцээ өндөр байна.

**Хүснэгт 9 Туслах малчин авах хэрэгцээтэй өрхийн тоо /сумдаар**

| № | Сумын нэрс | Туслах малчин авах өрхийн тоо | Туслах малчин авахгүй өрхийн тоо | Судалгаанд хамрагдсан нийт өрх |
|---|---|---|---|---|
| 1 | Сайнцагаан | 12 | 74 | 86 |
| 2 | Адаацаг | 1 | 50 | 51 |
| 3 | Баянжаргалан | 3 | 21 | 24 |
| 4 | Говь-Угтаал | 11 | 19 | 30 |
| 5 | Гурвансайхан | 8 | 53 | 61 |
| 6 | Дэлгэрхангай | 9 | 33 | 42 |
| 7 | Дэлгэрцогт | 10 | 24 | 34 |
| 8 | Дэрэн | 9 | 32 | 41 |
| 9 | Луус | 11 | 23 | 34 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 10 | Өлзийт | 7 | 36 | 43 |
| 11 | Өндөршил | 7 | 18 | 25 |
| 12 | Сайхан-Овоо | 7 | 35 | 42 |
| 13 | Хулд | 14 | 31 | 45 |
| 14 | Цагаандэлгэр | 2 | 24 | 26 |
| 15 | Эрдэнэдалай | 43 | 83 | 126 |
| **Нийт дүн** | | **154** | **556** | **710** |

**График 65 Туслах малчин ажиллуулдаг малчин өрх, малын тоогоор**




Малын тооноос хамаарч туслах малчин авдаг ба жилээс жилд малын тоо өсч байгаа учир туслах малчны эрэлт хэрэгцээ улам нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

**График 66 Ажил олгогч туслах малчинд тавьдаг нийтлэг шалгуур**




Дийлэнх малчид малч, хөдөлмөрч, итгэл даах, гэр бүлтэй, тогтвор суурьшилтай туслах малчин авах шаардлагыг нэн тэргүүнд тавьж байна.

**График 67 ААН болж өргөжих сонирхолтой малчин өрх, малын тоо, хувиар**




**Хүснэгт 10 Нөхөрлөл, хоршоо, ААН болох сонирхолтой малчин өрх, сумдаар**

| Сумын нэр | Нөхөрлөл | Хоршоо | ХХК | Сонирхолгүй өрх | Нийт өрх | ААН болох сонирхолтой өрхийн эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|
| Адаацаг | 0 | 13 | 0 | 38 | 51 | 25% |
| Сайнцагаан | 2 | 44 | 1 | 39 | 86 | 55% |
| Баянжаргалан | 8 | 8 | 0 | 8 | 24 | 67% |
| Говь-Угтаал | 1 | 25 | 0 | 4 | 30 | 87% |
| Гурвансайхан | 7 | 5 | 1 | 48 | 61 | 21% |
| Дэлгэрхангай | 21 | 17 | 0 | 4 | 42 | 90% |
| Дэлгэрцогт | 3 | 11 | 1 | 19 | 34 | 44% |
| Дэрэн | 19 | 1 | 0 | 21 | 41 | 49% |
| Луус | 0 | 1 | 0 | 33 | 34 | 3% |
| Өлзийт | 4 | 15 | 0 | 9 | 43 | 44% |
| Өндөршил | 3 | 4 | 3 | 16 | 25 | 40% |
| Сайхан-Овоо | 0 | 27 | 1 | 14 | 42 | 67% |
| Хулд | 14 | 13 | 1 | 17 | 45 | 62% |
| Цагаандэлгэр | 4 | 4 | 0 | 18 | 26 | 31% |
| Эрдэнэдалай | 2 | 54 | 0 | 70 | 126 | 44% |
| **Нийт дүн** | **88** | **242** | **8** | **358** | **710** | 48% |

Дэлгэрхангай, Говь-Угтаал, Баянжаргалан, Сайхан-Овоо, Хулд сумдын малчид хоршин ажиллах, үйл ажиллагаа өргөжүүлэх сонирхол давамгай байна.

**График 68 ААН болох сонирхолтой малчин өрхийн тоо, аж ахуйн төрлөөр**




Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 48 хувь нь ААН болох сонирхолтой байгаагаас 72 % нь хоршоо, 26 % нь нөхөрлөл болох сонирхолтой байгаа нь цаашид малчны сургалтын агуулгад нөхөрлөл, хоршоо байгуулах арга замыг оруулж, дэмжиж ажиллах шаардлага байна

**График 69 Судалгаанд хамрагдсан малчин өрхөд ААН болох сонирхолтой малчин өрхийн эзлэх хувь, сумдаар**




Дэлгэрхангай, Говь-Угтаал сумдын малчин өрхийн 87-90 хувь нь, Баянжаргалан, Сайхан-Овоо, Хулд сумдын малчин өрхийн 62-67 хувь ААН байгуулж ажиллах сонирхолтой байгаа нь бусад сумдтай харьцуулахад өндөр үзүүлэлттэй байна.

**График 70 Нөхөрлөл, хоршоо болох сонирхолтой малчин өрхийн тоо, сумдаар**




Сайнцагаан, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Өлзийт, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдын малчин өрхүүд хоршоо болох сонирхол нь илүү бол Дэрэн сумын малчин өрхүүдээс нөхөрлөл болох сонирхолтой өрхийн тоо давуу байхад Дэлгэрхангай, Хулд, Баянжаргалан сумдад нөхөрлөл, хоршоо болох өрхийн тоо ойролцоо байна. Энэ нь малчин өрхүүд хамтарч, хоршиж ажиллах сонирхолтойг илтгэж байгаа тул ямар хэлбэрээр, яаж хүчээ нэгтгэн хамтран ажиллавал үр дүнд хүрч болох талаар сургалт, зөвлөгөө өгч, гадаад, дотоодын амжилттай хэрэгжсэн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, нэвтрүүлэх нь чухал байна.

**График 71 Хүүхдээ малчин болгох сонирхолтой малчин өрхийн тоо, малын тоогоор**




Судалгаанд хамрагдсан 710 өрхийн 356 малчин буюу 50 гаруй хувь нь 500-аас дээш тооны малтай малчин өрхүүд өөрийн хүүхдээ малчин болгож, үргэлжлүүлэн уламжлалт аргаар малаа өсгөх бодлоготой байна.

**График 72 Судалгаанд хамрагдсан нийт малчин өрхөд хүүхдээ малчин болгох сонирхолтой өрхийн эзлэх хувь, малын тоогоор**




Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 63% нь хүүхдээ малчин болгоно гэсэн бол үүнээс 500-аас дээш малтай малчин өрхийн хувьд энэ үзүүлэлт илүү өндөр хувьтай байгаа нь цаашид малчдад өөрийн залуу халаат бэлтгэх хэрэгцээ байгааг харуулж байна.

**График 73 Малчдын сургалтын хэрэгцээ, хувиар**




Сургалт хэрэгггүй, мэдэхгүй гэсэн хариултын эзлэх хувь бага байгаа нь малчид өөрсдийгөө чадавхжуулж, мал аж ахуйн салбарын шинэлэг зүйлийг суралцах, үйлдвэрлэгч болох хүсэл эрмэлзлэл их байгаа нь харагдаж байна. Ялангуяа малын эрүүл мэнд, мал аж ахуй, түүхий эд бэлтгэх боловсруулах, бэлчээр газар тариалангийн чиглэлээр суралцах сонирхолтой малчны эзлэх хувь нь илүү байна.

Хот, суурин газраас хөдөөд шилжин суурьшиж мал маллах хүсэлтэй гэрээт малчин болон малаа гэрээ хийж маллуулах туслах малчин хайж буй ажил олгогч малчдад хөдөлмөрийн гэрээ байгуулах арга зүй, хөдөлмөрийн тухай хуулийн мэдэгдэхүүнтэй болгох сургалтыг 2018 оны 08 дугаар сарын 29-30 өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад 9 сумын 2018 оны “Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төсөл”-д хамрагдах хүсэлт гаргасан нийт 30 ажил олгогч хамрагдсан. Сургалтад хамрагдсан малчин ажил олгогчийн оролцоотойгоор гэрээт малчны хийх үүрэг, ажилбаруудыг DACUM аргаар боловсруулан чанарын судалгаа хийсэн. Энэ нь ажил олгогч малчид гэрээт малчинтай хийх хөдөлмөрийн гэрээндээ тэдний хийх ажил, үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар болсон юм. Чанарын судалгааг хавсралт 3-т тусгасан.

## ДҮГНЭЛТ

Судалгаанд хамрагдсан малчин өрхийн тэргүүлэгчдийн 70-гаруй хувийг 36-аас дээш насныхан эзэлж байгаа нь залуу малчдын эзлэх хувь бага байгааг илтгэж байна. Харин 60-аас дээш настай, ахмад туршлагатай малчдын тоо цөөрч байгаа тул тэдний туршлагыг залуучуудад өвлүүлэх ажлыг зохион байгуулах хэрэгтэй байна. Боловсролын хувьд судалгаанд хамрагдсан малчин өрхийн тэргүүний 93 хувь нь бүрэн дундаас доош түвшинд байна. Харин сүүлийн жилүүдэд залуучууд их дээд сургууль, коллеж, МСҮТ төгсөөд хөдөө гарч ажиллах хандлага нэмэгдэж байгаа тул үүнийг бодлогоор дэмжвэл илүү үр дүн гарах боломжтой юм.

Судалгаанаас үзэхэд туслах малчинтай өрх бага хувийг эзэлж байгаа боловч цаашид туслах малчин авах сонирхол их байгаа нь харагдаж байна. Малчин өрхүүд туслах малчинд хөдөлмөрч ажилсаг, малч, гэр бүлтэй тогтвор суурьшилтай ажиллах шалгууруудыг голлон тавьж байгаа нь энэ салбарын хөдөлмөрийн зах зээлийг бүрдүүлэхэд анхаарах чухал үзүүлэлт болно. Судалгаанд 154 туслах малчны хэрэгцээ шаардлага байгааг илэрхийлсэн ба аймгийн нийт 8283 малчин өрхөд харьцуулахад хөдөлмөрийн зах зээлд 1000 гаруй туслах малчны эрэлт, хэрэгцээг зохицуулах, ажлын байрыг нэмэгдүүлж болох юм.

Аймгийн хэмжээнд тэтгэврийн насны 1864 малчин байдаг ба судалгаанаас үзэхэд малчин өрхийн тэргүүн нийгмийн даатгалд хамрагддаг ч гэр бүлийн бусад гишүүдийн хамрагдалт бага байна. Энэ нь улс, аймгийн аварга малчны шалгуур болон банкны зээлийн шалгуурт зөвхөн өрхийн тэргүүлэгчийг нийгмийн даатгалд хамрагдсан байх шалгуур тавьдгаас болж нэг талаас ийм байдал үүссэн байж болно. Цаашид гэр бүлийн гишүүдийг нийгмийн

даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах нь зүйтэй. Мөн 36-55 насны малчдын нийгмийн даатгалд хамрагдалт өндөр байгаа ч залуучуудын хамрагдалт муу байгаа нь анхаарах асуудлын нэг юм.

Малчдын дийлэнх нь мал аж ахуйн, малч ухааны сургалт, малын эрүүл мэнд, боловсруулах үйлдвэрлэлийн мэдлэг, ур чадвар эзэмшихийг нэн тэргүүнд хүссэн бол нөгөө талаас гутал засвар, оёдол гэх зэрэг жижиг өрхийн үйлдвэрлэл явуулах боломжтой сургалтуудыг авах хэрэгцээ байна. Энэ нь малчид өөрсдийгөө олон талаас чадавхжуулах, ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлж байгаа гэж ойлгож болно.

Эдгээр малчин өрхийн 48 хувь нь ААН болох сонирхолтой байгаагаас 72 % нь хоршоо, 26 % нь нөхөрлөл болох сонирхолтой байгаа нь цаашид малчны сургалтын агуулгад нөхөрлөл, хоршоо байгуулах арга замыг оруулж, дэмжиж ажиллах шаардлага байгааг харуул байна.

Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 63% нь хүүхдээ малчин болгоно гэсэн бол үүнээс 500-аас дээш малтай малчин өрхийн хувьд энэ үзүүлэлт илүү өндөр хувьтай байна. Энэ нь малчдад өөрийн залуу халааг бэлтгэх хэрэгцээ байгааг илэрхийлж байна. Иймд залуу малчны сургалтыг үр дүнтэй, цаг хугацааны хувьд уян хатан, агуулгыг хэрэгцээнд суурилж боловсруулан зохион байгуулах эрэлт, хэрэгцээ байна гэж дүгнэж болох юм.

Иймд дээрх чиглэлээр сургалт явуулах, туслах малчдыг бэлтгэх, зуучлах тогтолцоог боловсронгуй болгож, мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж харагдаж байна.

### 3.4 АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АВСАН ТООН СУДАЛГААНЫ ДҮН

**График 74 Ажилгүй иргэдийн тоо, сумдаар**




Судалгаанд нийт 15 сумын 2060 ажилгүй иргэн хамрагдсанаас 47,8 хувийг Сайнцагаан сумын иргэд эзэлж байна.

**Хүснэгт 11 Аймгийн хэмжээний 15-дээш насны нийт хүн амд судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн эзлэх хувь, насны ангиллаар**

| Насны бүлэг | Дундговь аймгийн 15 дээш насны иргэдийн тоо | Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн тоо | Нийт хүн амд эзлэх хувь |
|---|---|---|---|
| 15-24 | 7962 | 325 | 4.1 |
| 25-34 | 7469 | 749 | 10.0 |
| 35-44 | 6462 | 505 | 7.8 |
| 45-54 | 5211 | 404 | 7.8 |
| 55-с дээш | 3424 | 77 | 2.2 |

Аймгийн хэмжээний 15-с дээш насны нийт хүн амд судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн эзлэх хувийг эзлэх хувийг насны ангиллаар харьцуулахад 25-34 насны иргэд 10 хувь, 35-44 насны иргэд 7.8 хувь, 45-54 насны иргэд 7.8 хувь, 15-24 насны иргэд 4.1 хувь, 55-аас дээш насны иргэд 2.2 хувийг тус тус эзэлж байна. 25-34 насны хөдөлмөрийн насны иргэдийн 10 хувь нь ажилгүй байна.

**График 75 Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн мэргэжил эзэмшсэн байдал, хувиар**

Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн 41 хувь нь бүрэн дунд буюу түүнээс доош боловсролтой, 39% нь мэргэжлийн боловсролтой иргэд байна.

**График 76 Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн мэргэжил эзэмшсэн байдал, хувиар**

Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн 59 хувь нь мэргэжил эзэмшсэн, 41 хувь нь мэргэжилгүй иргэд байна.




**Хүснэгт 12 Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн эзэмшсэн мэргэжил**




| № | Эзэмшсэн мэргэжил | Тоо | Үсгэн код | Индекс |
|---|---|---|---|---|
| | Нийт | 1117 | | |
| 1 | Жолооч | 153 | TC | 8331-14 |
| 2 | Тогооч | 115 | IF | 5120-11 |
| 3 | Багш | 79 | ET | 2330 |
| 4 | Шаварчин, засал чимэглэлчин | 75 | CF | 7123-20 |
| 5 | Оёдолчин, зөөлөн эдлэлийн | 54 | IE | 7533-28 |
| 6 | Барилгын өрөг угсрагч | 39 | CF | 7112-19 |
| 7 | Цахилгаанчин | 35 | CF | 7411-12 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | ХММО, жолооч | 34 | MT | 8111-35 |
| 9 | Үсчин | 32 | SO | 5141-11 |
| 10 | Мужаан | 31 | CF | 7115-24 |
| 11 | Нягтлан бодогч | 31 | BF | 2411-18 |
| 12 | Автомашинызасварчин | 29 | TC | 8211-20 |
| 13 | Гагнуурчин | 25 | IM | 7212-14 |
| 14 | Эдийн засагч | 25 | | 2631-11 |
| 15 | Сантехникч, барилгын | 22 | CF | 7126-36 |
| 16 | Эрхзүйч, хуульч | 18 | | 2611-11 |
| 17 | СӨБ багш | 18 | ET | 5312-11 |
| 18 | Худалдагч | 15 | BT | 5223-15 |
| 19 | Компьютерийн операторчин, техник хангамж | 15 | IO | 4120-13 |
| 20 | Архив бичиг хэргийн ажилтан Нарийн бичгийн дарга | 14 | ID | 4120-11 |
| 21 | Төрийн захиргааны удирдлага | 13 | | 1112 |
| 22 | Малын эмч, мал зүйч, зоо техникч | 13 | | 2250-22 |
| 23 | Банк, санхүү | 11 | BF | 4312 |
| 24 | Гоосайханч | 10 | SO | 5142-11 |
| 25 | Инженер 2149 | 8 | PS | 2141 |
| 26 | Нярав | 7 | BT | 4321-17 |
| 27 | Холбооны техникч | 7 | PB | 7422-18 |
| 28 | Бизнесийн удирдлага | 7 | BT | 1219 |
| 29 | Нарийн боовчин | 7 | IF | 7512-34 |
| 30 | Сувилагч | 6 | HO | 3256-14 |
| 31 | ЭМ зүйч | 6 | HO | 2262-11 |
| 32 | Аялал жуулчлалын ажилтан | 6 | NT | 5111-14 |
| 33 | Компьютер, Программ хангамжын инженер | 5 | | 2519 |
| 34 | Хэлсудлаач | 5 | | 2643-25 |
| 35 | Нийгмийн ажилтан | 5 | ET | 2635-11 |
| 36 | Орчуулагч | 5 | ET | 2643-25 |
| 37 | Уул уурхайн инженер | 4 | MG | 2146-19 |
| 38 | Бетон арматурчин | 4 | CF | 7114-20 |
| 39 | Гаалийн ажилтан | 4 | | 3351-11 |
| 40 | Газар зохион байгуулагч | 4 | | 2165-11 |
| 41 | Соёлын менежер | 4 | | 1431-18 |
| 42 | Хөгжимчин | 4 | AM | 2652-11 |
| 43 | Гуталчин | 4 | SO | 7536-22 |
| 44 | Ойжуулагч | 3 | NF | 6210-21 |
| 45 | Өрмийн мастер,  туслах | 3 | MR | 8111-25 |
| 46 | Уул уурхайн баяжуулагч | 3 | MR | 3117-26 |
| 47 | Цахилгааны инженер 3113 | 3 | PL | 2151-11 |
| 48 | Усны инженер, Гидро механик-2149-59 | 3 | NG | 2142-40 |
| 49 | Худалдааны менежер | 3 | SO | 1420-12 |
| 50 | Хүнсний эрүүл ахуйч | 3 | HO | 2265-13 |
| 51 | Сэтгүүлч | 3 | | 2642-11 |
| 52 | Эх бэлтгэгч | 3 | | 4132-16 |
| 53 | Их эмч, багаэмч | 3 | | 2211-11 |
| 54 | Дизайнар | 3 | AD | 7532-27 |
| 55 | Дуучин | 3 | AS | 2652-38 |
| 56 | Мах сүүний технологич | 3 | | |
| 57 | Оёдлын технологич | 3 | IE | 3139-14 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 58 | Жимс ногооны мэргэжилтэн | 2 | AF | 6112-13 |
| 59 | Лабортарын техникч-3133-13 | 2 | AT | 3115-29 |
| 60 | ХАА механикжуулалтын техникч AT 3115-29 | 2 | AT | 3142-18 |
| 61 | Дулааны инженер 2142-22 | 2 | PS | 2141-49 |
| 62 | Замчин | 2 | CB | 7116-18 |
| 63 | Тоног төхөөрөмжийн засварчин | 2 | CF | 7126-26 |
| 64 | Улс төр судлаач | 2 | | 2633-18 |
| 65 | Холбооны инженер | 2 | PC | 2153-11 |
| 66 | Хүний нөөцийн менежер | 2 | | 1212-12 |
| 67 | Байгаль ашиглалт хяналт үнэлгээ | 2 | | 2133 |
| 68 | Байгаль хамгаалагч | 2 | NE | 3257-20 |
| 69 | Шүдний эмч | 2 | HO | 2261-11 |
| 70 | Ландшафтаны архитектур | 1 | AF | 2133 |
| 71 | Геологийн мастер | 1 | MG | 3111-16 |
| 72 | Далд уурхайн мэргэжилтэн | 1 | MT | 8111-18 |
| 73 | Хүнд машин механизм ашиглалтын инженер-3115-55 | 1 | | 2144 |
| 74 | Уул уурхайн нөхөн сэргээлт | 1 | MG | 6210-28 |
| 75 | Мебелийн технологич | 1 | IE | 3115-58 |
| 76 | Металл боловсруулагч | 1 | IM | 7223-17 |
| 77 | Модон эдлэлийн технологич | 1 | IS | 3119-28 |
| 78 | Сийлбэрчин | 1 | AM | 7313-28 |
| 79 | Сүлжигч | 1 | IE | 8152-33 |
| 80 | Үйлдвэрийнтехникч | 1 | IM | 3119-14 |
| 81 | Үйлдвэрлэлийн технологич | 1 | IM | 3119-29 |
| 82 | Гидротехникч | 1 | CT | 3112-22 |
| 83 | Арихтектурч | 1 | CF | 2161-11 |
| 84 | Барилгын инженер | 1 | CF | 2142-16 |
| 85 | Барилгын техникч | 1 | CF | 3112-11 |
| 86 | Барилгын лаборант | 1 | CF | |
| 87 | Автын инженер-8211 | 1 | TC | 2144-15 |
| 88 | Төмөр замын засвар техник | 1 | TR | 3115-63 |
| 89 | Дохиолол төвлөрүүлэгч | 1 | TR | 3115-64 |
| 90 | Зөөгч, бармен | 1 | IF | 5131-11 |
| 91 | Хоол үйлдвэрлэл технологич | 1 | IF | 3434-14 |
| 92 | Электроникийн инженер-2144-26 | 1 | IT | 2151 |
| 93 | Дүрслэх урлаг, график | 1 | IT | 3512-15 |
| 94 | Зурагчин | 1 | AC | 3431-14 |
| 95 | Газар зохион байгуулалтын инженер | 1 | | 2149 |
| 96 | Газрын тос | 1 | MF | 3117-12 |
| 97 | Цагуурын инженер-2141 | 1 | NW | 2112-11 |
| 98 | Байцаагч | 1 | | 2133 |
| 99 | Хөдөлмөр хамгаалалын инженер 2149 | 1 | | 2141-25 |
| 100 | Цагдаа, харуул хамгаалалт | 1 | MP | 5412-12 |
| 101 | Дасгалжуулагч | 1 | | 3422-11 |
| 102 | Бариа засалч | 1 | HO | 5321-15 |
| 103 | Нүүр амны техникч | 1 | HO | 3251-13 |
| 104 | Сэтгэл судлаач | 1 | | 2634-12 |
| 105 | Уламжлалын эмч | 1 | HO | 2230-14 |
| 106 | Бүжигчин | 1 | AB | 2653-15 |
| 107 | Жүжигчин | 1 | AA | 2655-12 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 108 | Киномеханикч | 1 | АС | 3115-22 |
| 109 | Гарурлал | 1 | АМ | 7319 |
| 110 | Дархан | 1 | АМ | 7313-19 |
| 111 | Үйлчлэгч | 1 | | 9112 |
| 112 | Гадаад харилцааны ажилтан | 1 | | 3359 |

**Хүснэгт 13 Судалгаанд хамрагдсан хос мэргэжил эзэмшсэн ажилгүй иргэд /Тоо/**

| 11 | Эзэмшсэн мэргэжил | Тоо |
|---|---|---|
| | Нийт | **94** |
| **1** | Автозасварчин, Жолооч | 3 |
| **2** | Нийгмийн бодлогын мэргэжилтэн, багш | 1 |
| **3** | Аялал жуулчлалын хөтөч, Орчуулагч, Албан бичиг, архив хөтлөлт | 1 |
| **4** | Багаэмч, Сувилагч | 1 |
| **5** | Барилгын засал чимэглэлч, Үсчин | 1 |
| **6** | Барилгын өргөн мэргэжил, Жолооч | 2 |
| **7** | Барилгын өрлөгчин, Гагнуурчин | 1 |
| **8** | Барилгын өрөг угсрагч, Тогооч | 1 |
| **9** | Бизнесийн удирдлага, Холбооны инженер | 1 |
| **10** | Гагнуурчин,  Сийлбэрчин | 1 |
| **11** | Гар утас засварчин, Жолооч | 1 |
| **12** | Зоотехникч, бариа заслын сувилагч | 1 |
| **13** | Жужигчин, Оёдолчин | 1 |
| **14** | Засал чимэглэл, Нягтлан | 1 |
| **15** | Инженер, механик, Гоозасалч, Маникюр | 1 |
| **16** | Компьютернарийнбичиг, Оёдолчин | 1 |
| **17** | Компьютер, оператор, Архив албан хэрэг хөтлөлт | 1 |
| **18** | Комьютерийн операторчин, Цэцэрлэгийн туслах багш | 1 |
| **19** | Малынэмч, Нярав | 2 |
| **20** | Мужаан, Арматурчин | 1 |
| **21** | Мужаан, Барилгын өрлөгчин | 1 |
| **22** | Мужаан, Жолооч | 2 |
| **23** | Нийгмийн ажилтан, Сэтгэл судлаач | 1 |
| **24** | Номын санч, Үсчин | 1 |
| **25** | Нягтлан бодогч, Эдийн засагч | 2 |
| **26** | Нягтлан бодох бүртгэл, Хүний нөөц бичиг хэрэг | 2 |
| **27** | Нярав, Нягтлан | 4 |
| **28** | Оёдол бүтээгдэхүүн, СӨБ туслах багш | 2 |
| **29** | Оёдолчин, Барилгачин | 1 |
| **30** | Оёдолчин, Үсчин | 2 |
| **31** | Оёдол-эсгүүрчин, Гуталчин | 1 |
| **32** | Олон улсын гааль татварын мэргэжилтэн, Нягтлан бодогч | 1 |
| **33** | Олон улсын мэргэшсэн банк, санхүү, Ня-бо бүртгэл | 1 |
| **34** | Сантехникч, Барилгын засал чимэглэл | 1 |
| **35** | Саниторч, автозасварчин | 1 |
| **36** | Гагнуур-сантехникч | 1 |
| **37** | Санхүү, Эдийн засаг | 3 |
| **38** | Сувилагч, Албан хэрэг хөтлөгч архив | 3 |
| **39** | Технологийн багш, Хосолсон үсчин | 1 |
| **40** | Тогооч, Жолооч | 1 |
| **41** | Тогооч, Нарийн боов | 3 |
| **42** | Тогооч, Оёдолчин | 4 |
| **43** | Тогооч, Ойжуулагч | 1 |
| **44** | Тогооч, Үсчин | 3 |
| **45** | Тогооч, Худалдагч | 4 |
| **46** | Тогооч, Цэцэрлэгийнбагш | 7 |

| | | |
|---|---|---|
| **47** | Үйлдвэрийн технологич, үсчин | 1 |
| **48** | Үсчин, Автозасварчин | 1 |
| **49** | Үсчин, Гоосайхан, маникюр шивээчин | 6 |
| **50** | Үсчин, Жолооч | 2 |
| **51** | Худалдагч, Нярав | 3 |
| **52** | Цахилгаанчин, Жолооч | 2 |

Хүснэгт 12, хүснэгт 14-өөс харахад 112 мэргэжлээр 1117 иргэн, хос мэргэжилтэй 94 иргэн тус тус бэлтгэгдсэн ба бакалаврын түвшинд багш, мэргэжлийн боловсролын сургалт, модуль сургалтаар бэлтгэгдсэн жолооч, тогооч, шаварчин, засалчин, оёдолчин, барилгын өргө угсрагч, цахилгаанчин, хүнд машин механизмын оператор, үсчин, мужаан мэргэжилтэй ажилгүй иргэд дийлэнх нь байна.

**График 77 Судалгаанд хамрагдсан мэргэжилтэй, мэргэжилгүй ажилгүй иргэдийн дахин суралцах байдал, хувь**




Суралцах сонирхолтой ажилгүй иргэд нийт судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн 52% эзэлж байгаа нь иргэдийн мэргэжил сонголт, хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй ажлын байр, шинээр бий болох мэргэжил, үйлдвэрлэл томоохон бүтээн байгуулалтуудын талаар мэдлэг мэдээлэл хомс байгааг харуулж байна. Цаашид холбогдох байгууллагууд хамтран хөдөлмөрийн зах зээлд бий болж буй эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг арилгах чиглэлээр шат дараатай арга хэмжээ авч, иргэдтэй хамтран ажиллах хэрэгцээтэй байна.

**График 78 Ямар түвшний сургалтад хамрагдах эсэх, хувь**




Судалгаанд хамрагдсан иргэдийн 33 хувь мэргэжилтэй боловч дахин суралцах сонирхолтой, 19 хувь нь эзэмшсэн мэргэжилгүй тул мэргэжил эзэмших сонирхолтой байна.

Шинээр мэргэжлийн чадамж эзэмших, ур чадвараа дээшлүүлэх, давтан сурах хүсэлтэй иргэдийн 66 хувь нь богино хугацааны сургалтаар мэргэжлийн ур чадвартай болох, ур чадвараа дээшлүүлэх хүсэлтэй байна.

**График 79 Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэд, мэргэжилгүй, суралцах сонирхолгүй ажилгүй иргэд насаар**

Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн насны дунд мэргэжилгүй атлаа суралцах сонирхолгүй ажилгүй иргэдийн насаар эзлэх хувийг харахад 55-аас дээш насны 41.6 хувь, 45-54 насны 34.9 хувь, 35-44 насны 30.3 хувь, 25-34 насны 13 хувь, 15-24 насны 11,1 хувь байна.




**График 80 Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэд, мэргэжилтэй, суралц**

| Насны бүлэг | Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн тоо | Мэргэжилтэй суралцах сонирхолтой ажилгүй иргэд | Нийт хүн амд эзлэх хувь |
|---|---|---|---|
| 15-24 | 325 | 136 | 41,8 |
| 25-34 | 749 | 320 | 42,7 |
| 35-44 | 505 | 136 | 26,9 |
| 45-54 | 404 | 72 | 17,8 |
| 55-с дээш | 77 | 9 | 11,7 |




**ах сонирхолтой ажилгүй иргэд насаар**

Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн насны дунд мэргэжилтэй суралцах сонирхолтой ажилгүй иргэдийн насаар эзлэх хувийг харахад 15-24 насны 41.8 хувь, 25-34 насны 42.7 хувь, 35-44 насны 26.9 хувь, 45-54 насны 17.8 хувь 55-аас дээш насны 11.7 хувь байна.

Мэргэжилтэй боловч дахин суралцах сонирхолтой ажилгүй иргэд 15-34 насны иргэд давамгай байна. График 80, 81-ээс харахад залуучуудын суралцах сонирхол их, нас ахих тутам иргэдийн суралцах сонирхол буурч байгаа нь харагдаж байна.

График 81 **Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэд, ажил эрхлээгүй хугацаагаар /хувь/**




**График 82 Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэд ажил эрхлэхгүй байгаа шалгаан /хувь/**




Судалгаанд хамрагдсан иргэдийн 66 хувь нь 24 сараас дээш хугацаанд ажил эрхлээгүй, ажил эрхлэхгүй байгаа шалтгаан 24.3 хувь нь мэргэжилгүй, 24.3 хувь нь мэргэжилд тохирох

ажил олдохгүй, 10.9 хувь нь 40-өөс дээш настай, 8.9 хувь нь хүүхэд харах хүнгүй, 6.8 хувь нь ажлын байр олдохгүй байна гэж хариулжээ. Мэргэжилгүй, мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа ажилгүй иргэдийн мэдээллийг график 78-аас харахад мэргэжил эзэмшсэн ажилгүй иргэдийн 33 хувь нь дахин суралцах, мэргэжилгүй ажилгүй иргэдийн 19 хувь нь мэргэжил эзэмшвэл ажлын байртай болно гэж үзэж байгаа нь харагдаж байна.

**График 83 Судалгаанд хамрагдсан иргэдийн ажилгүй байгаа шалтгаан, хугацаа /хувь/**




Судалгаанд хамрагдсан иргэдийн ажил эрхлэхгүй байгаа шалтгааныг, ажил эрхлэхгүй байгаа хугацаатай харьцуулж харахад 24 сараас дээш буюу урт хугацаанд ажилгүй байгаа шалтгаан нь 40-өөс дээш настай тул ажилд авдаггүй 82 хувь, эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй байгаа 78 хувь, мэргэжилгүй тул ажил эрхлэхгүй байгаа 78 хувь, мэргэжил ур чадвар хүрэлцэхгүй байгаа 73 хувь байна.

**График 84 Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн ажиллахыг хүсч буй ААН, байгууллагын хэлбэр**




Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн 35,5 хувь нь төрийн байгууллагад, 35,2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэх, 16,3 хувь нь ААНэгжид, 6,8 хувь нь ажлын байр олдвол хаана ч хамаагүй гэжээ.

**График 85 Хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэдэд шаардлагатай туслалцаа, дэмжлэг, хувь**




График 87-аас харахад судалгаанд хамрагдсан иргэдийн 35,2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй гэж хариулсан бөгөөд хувиараа хөдөлмөр эрхлэхэд хөрөнгө, санхүү /барьцаа хөрөнгө бага шаарддаг хүү багатай зээл/, тоног төхөөрөмж, ажлын байр шаардлагатай нь харагдаж байна.

**График 86 Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн ажлын туршлага /хувь/**




Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн ажлын туршлагыг судлан үзэхэд 44 хувь ажлын туршлагагүй, 39 хувь нь хувийн хэвшил, 17 хувь нь төрийн байгууллагад ажиллаж байсан туршлагатай байна.

**Хүснэгт 14 Дундговь аймгийн ажилгүй иргэдийн сургалтын хэрэгцээ /судалгааны дүн**

| Салбар | Эзэмшсэн мэргэжил | Тоо | Үсгэн код | Индекс |
|---|---|---|---|---|
| 1.Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт,ан агнуур/тариаланч, ногоочин, малчин, амьтан маллагч, газар тариаланч, фермч / | Жимс ногооны мэргэжилтэн | 2 | AF | 6112-13 |
| | Малчин | 5 | | 6320-11 |
| | Ойжуулагч | 3 | NF | 6210-21 |
| | **10** | | | |
| 2.Уул уурхай, олборлолт/Бичил уурхай/ | Далд уурхайн мэргэжилтэн | 11 | MT | 8111-18 |
| | Уул уурхайн инженер | 1 | MG | 2146-19 |
| | 12 | | | |
| 3.Боловсруулах үйлдвэр/Блок,тоосго, модон эдлэл, ноос, арьс ширээр үйлдвэрлэгч/ | Мужаан | 22 | CF | 7115-24 |
| | 22 | | | |
| 4.Цахилгаан, хий, уур, агааржуулалт/гагнуурын үйл ажиллагаа/ | Гагнуурчин | **59** | IM | 7212-14 |
| | Цахилгаанчин | **42** | CF | 7411-12 |
| | 101 | | | |
| 5.Ус хангамж: Бохир ус зайлуулах, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйлажиллагаа | Усны инженер, Гидро механик-2149-59 | 2 | NG | 2142-40 |
| | 2 | | | |
| 6.Барилга /Барилгачин, өрөгч, хэв цутгагч г.мэт/ | Барилгын инженер | 8 | CF | 2142-16 |
| | Барилгын Өрөг угсрагч | 15 | CF | 7112-19 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Бетон арматурчин | 1 | CF | 7114-20 |
| | Инженер 2149 | 3 | PS | 2141 |
| | Сантехникч, барилгын | 14 | CF | 7126-36 |
| | Шаварчин, засал чимэглэлчин | 13 | CF | 7123-20 |
| | 54 | | | |
| 7.Бөөний болон жижиглэн худалдаа: /Машин болон мотоциклын засвар,дугуй засвар / | Автомашины засварчин | 24 | TC | 8211-20 |
| | автын инженер-8211 | 2 | TC | 2144-15 |
| | Худалдагч | 8 | BT | 5223-15 |
| | 34 | | | |
| 8.Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа/ачаа болон хүн тээврийн үйлчилгээ / | Жолооч | **55** | TC | 8331-14 |
| | ХММО, жолооч | **41** | MT | 8111-35 |
| **Нийт дүн** | 96 | | | |
| 9.Зочид буудал, байр,нийтийн хоолны үйлчилгээ/Хоол үйлдвэрлэл, караоке бар/ | Зохион байгуулалтын менежер | 3 | | 1221-12 |
| | Тогооч | **147** | IF | 5120-11 |
| | Хоол үйлдвэрлэл Технологич | 1 | IF | 3434-14 |
| | Хүнсний эрүүл ахуйч | 1 | HO | 2265-13 |
| **Нийт дүн** | 152 | | | |
| 10. Мэдээлэл холбоо | Компьютерийн операторчин, техник хангамж | 22 | IO | 4120-13 |
| | Сэтгүүлч | 1 | | 2642-11 |
| **Нийт дүн** | 23 | | | |
| 11.Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | Банк, санхүү | 26 | BF | 4312 |
| | Нягтлан бодогч | **56** | BF | 2411-18 |
| | Нярав | 17 | BT | 4321-17 |
| **Нийт дүн** | 99 | | | |
| 12.Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | Газар зохион байгуулагч | 3 | | 2165-11 |
| **Нийт дүн** | 3 | | | |
| 14.Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | Бизнесийн удирдлага | 4 | BT | 1219 |
| | Хүний нөөц | 8 | | 1212-12 |
| **Нийт дүн** | 12 | | | |
| 15. Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа | Төрийн захиргааны удирдлага | 9 | | 1112 |
| **Нийт дүн** | 9 | | | |
| 16.Албан журмын нийгмийн хамгаалал | Байгаль ашиглалт хяналт үнэлгээ | 3 | | 2133 |
| | хөдөлмөр хамгаалалын инженер 2149 | 8 | | 2141-25 |
| | Цагдаа, харуул хамгаалалт | 5 | MP | 5412-12 |
| | Эрх зүйч, хуульч | 23 | | 2611 |
| **Нийт дүн** | 39 | | | |
| 17.Боловсрол /сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчид, номын санч, архивч/ | Архив бичиг хэргийн ажилтан Нарийн бичгийн дарга | 9 | ID | 4120-11 |
| | Боловсролын удирдлага | 1 | | 1345-11 |
| | Багш | 28 | ET | 2330 |
| | Номын санч | 1 | | 2622-18 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Нийгмийн ажилтан | 3 | ET | 2635-11 |
| | Орчуулагч | 8 | ET | 2643-25 |
| | СӨБ туслах багш | 30 | | |
| | СӨБ багш | 17 | ET | 5312-11 |
| **Нийт дүн** | 97 | | | |
| 18. Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа/эх баригч, сувилахуйн мэргэжилтэн, эмийн сан, малын эмч/ | Бариа засалч | 4 | HO | 5321-15 |
| | ИхЭмч, бага эмч | 2 | | 2211-11 |
| | Малын эмч, мал зүйч, зоо техникч | 9 | | 2250-22 |
| | Нүүр амны техникч | 1 | HO | 3251-13 |
| | Сувилагч | 12 | HO | 3256-14 |
| | Сэтгэл судлаач | 3 | | 2634-12 |
| | Эх баригч эмч | 1 | | 2222-11 |
| | Шүдний эмч | 2 | HO | 2261-11 |
| | Эм зүйч | 6 | HO | 2262-11 |
| | 40 | | | |
| 19. Урлаг, үзвэр, тоглоом наадам/кино театр, pc тоглоомын газар/ | Дизайнар | 1 | AD | 7532-27 |
| | Дуучин | 7 | AS | 2652-38 |
| | Соёлын менежер | 2 | | 1431-18 |
| | Хөгжимчин | 4 | AM | 2652-11 |
| | 14 | | | |
| 20. Үйлчилгээний бусад үйл ажиллагаа/алт мөнгөний дархан, үсчин гоо сайханч,оёдол, эсгий сүлжмэл эдлэл, талх нарийн боов/ | Гар урлал | 18 | AM | 7319 |
| | Гоо сайханч | **44** | SO | 5142-11 |
| | Гуталчин | 8 | SO | 7536-22 |
| | Гар утас засварчин | 6 | | |
| | Дархан | 1 | AM | 7313-19 |
| | Жижүүр, манаач | 1 | | 9629-18 |
| | Нарийн боовчин | 21 | IF | 7512-34 |
| | Галч | 1 | | 9629-17 |
| | Оёдолчин, зөөлөн эдлэлийн | **114** | IE | 7533-28 |
| | Үйлчлэгч | 4 | | 9112 |
| | Үсчин | 84 | SO | 5141-11 |
| | 302 | | | |
| 22. Олон улсын байгууллага суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа / | Аялал жуулчлалын ажилтан | 2 | NT | 5111-14 |
| | Гадаад харилцааны ажилтан | 1 | | 3359 |
| | 3 | | | |
| Мэргэжил дээшлүүлэх | Мэргэжил дээшлүүлэх | 45 | | |
| | 1124 | | | |
| Төлөвлөөгүй | Төлөвлөөгүй | **53** | | |
| **Нийт дүн** | 1222 | | | |

Судалгаанд хамрагдсан ажилгүй 147 иргэн тогооч, 114 иргэн оёдолчин /зөөлөн эдлэлийн/, 59 иргэн гагнуурчин, 55 иргэн жолооч, 56 иргэн нягтлан бодогч мэргэжлээр суралцах сонирхолтой байна.

## ДҮГНЭЛТ

Статистикийн түүвэр судалгааны тархалтаар аймгийн хэмжээнд ажилгүй иргэн 1696, хүн ам өрхийн мэдээллийн сангийн судалгаагаар хөдөлмөр эрхэлдэггүй хөдөлмөрийн насны 3005 иргэн бүртгэлтэй байснаас Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд дахин нягталж судалгаа авах хугацаанд ажилгүй байсан 2060 иргэнийг судалгаанд хамруулсан. 2018 оны 4 дүгээр сарын 25-ны байдлаар хөдөлмөрийн зах зээлийн Lmis программд 642 иргэний мэдээлэл идэвхтэй төлөвт байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан 2060 иргэний 31 хувь нь ажил идэвхтэй хайж байна. Бусад 69 хувь нь ажил хийхийг хүсч байгаа боловч ажилгүйдэлд

бүртгүүлэх хэрэгтэй гэдгийг мэддэггүй байх магадлалтай юм. Иймд ажилгүй иргэдэд ажилгүйдэлд бүртгүүлэхийн давуу талыг ойлгуулж, иргэдэд ХЭДҮйлчилгээг илүү ойр чанартай хүргэж, итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх нь чухал асуудал болоод байна. Иргэдийн итгэл үнэмшил нэмэгдснээр бүртгүүлж, үйлчилгээ авах хүсэлтэй иргэдийн тоо нэмэгдэж, иргэдийн хэрэгцээнд тулгуурлан ХЭДҮйлчилгээ, арга хэмжээг үзүүлэх боломж бүрдэх юм.

Судалгаанд 2060 иргэн хамрагдсан бөгөөд 985 буюу 47,8 хувь нь Сайнцагаан сум, 195 буюу 9,5 хувь нь Хулд сум, 150 буюу 7,3 хувь нь Эрдэнэдалай сум, 126 буюу 6,1 хувь нь Дэлгэрхангай сумын ажилгүй иргэд хамрагдсан байна. Энэ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг дээрх сумдруу чиглүүлэх хэрэгцээ байгааг харуулж байна.

Ажилгүй иргэдийн дийлэнх нь 25-34 насны залуучууд, тэдгээрийн суралцах идэвх нь мөн давамгай байна. Энэ нь ажилгүй залуучууд ажил хийх хүсэлтэй байгаа төдийгүй ажил эрхлэхийн тулд мэргэжлээ солих эсвэл давтан сурах зорилго тавиад байгаа нь судалгаанаас харагдаж байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн ажилгүй байгаа шалтгааныг харахад мэргэжилд тохирох ажил олдохгүй, мэргэжилгүй, ажлын байр байхгүй шалтгаанаар удаан хугацаанд хөдөлмөр эрхлэхгүй байсаар байна.

Мэргэжилгүй иргэдэд мэргэжил эзэмшүүлэхийн тулд тэдэнд мэргэжил олгох сургалтыг ойртуулах, ахмад настан болон эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй болсон иргэдэд чиглэсэн өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ, явуулын үйлчилгээ эрхлэх боломж бүрдүүлэх зайлшгүй хэрэгцээтэй байна.

Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэд төрийн байгууллагад, эсвэл хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэл давамгай байна. Ажилгүй иргэд цагт хавчигдахгүй ажил хийх сонирхолтой буюу судалгаанд хамрагдсан иргэдийн 35.2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэхийг хүсч байна. Өөрийн давуу талд тулгуурлан өөрөө өөртөө ажлын байр бий болгох хүсэлтэй ирэгдийг мөн дэмжих бодлого дутагдалтай байна. Учир нь тэд хувиараа хөдөлмөр эрхлэх гэхэд санхүү дутагдалтай, банкны зээлийн нөхцөл өндөр, ажлын байр байхгүй зэрэг шалтгааны улмаас үйл ажиллагаагаа эхлүүлж чадахгүй байсаар байна.

Ажилгүй иргэдийн 44 хувь нь ямар нэгэн ажлын туршлагагүй, судалгаанд хамрагдсан иргэдийн 24 хувь нь мэргэжилд тохирох ажил олдохгүй байна гэж хариулнаас харахад орон нутагт ажлын байр хомс, ажилгүй иргэдийн хүссэн ажлын байр байхгүй байна гэж дүгнэж болохоор байна. Хийхийг хүссэн ажил нь олдохгүй удаан хугацаанд ажилгүй явсан иргэд ажил хийх дур сонирхол нь буурч амьжиргааны түвшин доошилсоор нэг л мэдэхэд бэлэнчлэх сэтгэлгээтэй, халамжаар амь зуугчдын тоо нэмэгдсээр байна. Иймд ажилгүй иргэдийг өөрийн хүч хөдөлмөрөөр хөдөлмөрлөж амьдрах сэтгэлгээг төлөвшүүлж, бэлэнчлэх сэтгэлгээг халахын тулд ажлын байрыг шинээр бий болгох зайлшгүй хэрэгцээ байна гэж үзлээ.

## 3.5 ИХ ДЭЭД СУРГУУЛЬД СУРАЛЦАЖ БУЙ ЗАЛУУЧУУДААС АВСАН ТООН СУДАЛГААНЫ ДҮН

Дундговь аймгийн хэмжээнд их дээд сургууль суралцаж буй 2018-2022 онд төгсөх оюутнуудын судалгаа. Уг судалгаанд нийт 1469 оюутан хамрагдсан байна.

**График 87 Их дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудыг сумдаар нь ангилвал**




Дээрхи судалгаанаас үзэхэд 2018-2022 онд хамгийн олон оюутан төгсөх сум нь Сайнцагаан 459, Эрдэнэдалай 199, Адаацаг 149 байна. Хүн амын төвлөрөл ихтэй сумд болоод аймгийн төвийн төгсөх оюутнуудын хувь их учир ажиллах хүчний нөөц их гэж үзэж байна.

**График 88 2018-2022 онд төгсөх оюутнуудын төгсөөд ажиллах газар, тоогоор**

Уг судалгаанаас үзхэд нийт судалгаанд хамрагдсан 1469 оюутны 634 оюутан сургуулиа төгсөөд аймаг орон нутагтаа ажиллаж амьдрах хүсэлтэй нь харагдаж байна. Харин 411 оюутан ажлын байр хаана байна тэнд очиж ажиллана. Үлдсэн 365 нь Улаанбаатар хотод ажиллаж амьдрана, 48 нь гадаадад, үлдсэн 11 нь огт бөглөөгүй байна.



**График 89 2018-2022 онд Их дээд сургууль төгсөх оюутнуудын суралцаж буй сургуулийн судалгаа**




Судалгаанаас үзэхэд Дундговь аймгаас хамгийн олон оюутан суралцаж байгаа сургуулиуд нь МУБИС, МУИС, АШУИС, ШУТИС, ИЗИС, МҮИС зэрэг сургуулиуд байна**.**

**График 90** Судалгаанд хамрагдсан оюутнуудын төгсөх жил, тоогоор




Судалгаанд нийт 1469 оюутан хамрагдсанаас 1446 нь төгсөх жилээ бөглөсөн бөгөөд үүний хамгийн их төгсөгч төгсөх он нь 2020 онд 376 төгсөгч, 2021 онд 363 төгсөгч, 2019 онд 305 төгсөгч, 2018 онд 276 төгсөгч, 2022 онд 98 төгсөгч, 2023 онд 24, 2024 онд 4 төгсөгч төгсөхөөр байна. 2023, 2024 онд төгсөх оюутнууд нь анагаахын оюутнууд байна.

График 91 Судалгаанд хамрагдсан оюутнуудын мэргэжил, тоогоор





Олон улсын бизнесийн харилцаа
1
Онцгой байдал хамгаалах алба
5
Олон улсын харилцаа
8
Нягтлан бодогч
55
Нүүр ам судлал
8
Ноосны технологич
3
Номын санч
1
Нисэх техникийн механик
1
Нийтийн удирдлага
5
Нийгмийн эрүүл мэнд судлаач
5
Нийгмийн ажилтан
19
Нийгмийн халамжийн мэргэжилтэн
1
Нарийн бичиг
2
Найруулагч
2
Мэргэжлийн хяналт
1
Мэдээлэл холбооны инженер
17
Мэдээлэл зүй
3
Мэдээллийн систем
3
Морин хуурч, язгуур урлаг
2
Механик инженер
9
Металл судлал
2
Машинист
3
Менежер, удирдлага
11
Маркетингийн менежмент
6
Малын эмч
33
Лам
10
Лаборатори шинжилгээ
1
Лаборант
3
Компьютерийн менежмент
12
Иргэний ба үйлдвэрлэлийн барилга
2
Интерьер дизайн
2
Геологийн инженер
1
Механикийн инженер
2
Инженер
67
Зураглаач
5
0
10
20
30
40
50
60
70
80


Улс төр судлаач 4
Уламжлалт сувилахуй 1
Уламжлалт анагаах ухаан 10
Түүх судлал 1
Тусгай хэрэгцээт боловсрол 1
Төрийн захиргаа удирдлага 9
Тоног төхөөрөмж ашиглалт, угсралт 1
Тогооч 8
Технологич 5
Техникийн инженер 1
Сэтгэл зүйч 8
Сэтгүүлч 10
Сэргээгдэх эрчим хүч 3
Судлаач 1
Сувилагч 25
Статистик 2
Социологич 3
Соёл судал 1
Системийн аюулгүй байдал 2
Санхүү эдийн засагч 61
Санхүү менежмент 2
Сантехникч 2
Радио техникч 2
Пропник 1
Программист 3
Программ хангамж 7
Өсвөр насны сэтгэл судлал 1
Офицер 2
Олон улсын эдийн засаг 1
Олон улсын гааль, татвар 2
Орчуулагч 18
Орон судлал 1
Олон улсын эрх зүй 2
Олон улсын худалдаа 1
0
10
20
30
40
50
60
70




Судалгаанд хамрагдсан нийт 1469 оюутны 1309 нь сурч буй мэргэжлээ бичсэн үлдсэн нь мэргэжлээ бичээгүй зарим нь 2-р курстээ мэргэжлээ сонгоно гэсэн байна. Дээрхи 1309 оюутан нь нийт 134 мэргэжлээр суралцдаг ба үүний дийлэнх нь буюу багш мэргэжлээр суралцаж байгаа 245 оюутан, эмч мэргэжлээр суралцаж байгаа 116 оюутнууд байна.

**График 92 Орон нутагтаа ажиллаж амьдрах сонирхолотой оюутнуудын тоо, мэргэжлээр**






Судалгааны дүнд орон нутагтаа амьдрах сонирхолтой 634 оюутан байгаагаас нийт 434 оюутан судалгаанд мэргэжлээ бөглөсөн байна. Дундговь аймгийн 2018-2022 онд төгсөх оюутнууд 134 мэргэжлээр суралцдаг бол төгсөөд орон нутагтаа ирж ажиллах хүсэлтэй оюутнуудын мэргэжил 91 байна. Үүнээс хамгийн их оюутан суралцаж буй мэргэжил нь багш ба нийт 98 оюутан байна**.**

**График 93 Орон нутагтаа ажиллах 98 багшийн мэргэжлийн чиглэл, тоогоор**




Судалгаанд нийт орон нутагтаа ирж ажиллах хүсэлтэй багшийн мэргэжлээр суралцаж буй 98 багш байгаагаас хамгийн их нь бага ангийн багш 23 байна. 68 оюутан мэргэжлийн чэглэлээ бичсэн бол үлдсэн оюутнууд мэргэшлийн чиглэлээ бичээгүй байна.

### 3.5 МСҮТ-Н СУРАЛЦАГЧДААС АВСАН ТООН СУДАЛГААНЫ ДҮН

Дундговь аймаг дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2017-2018 оны хичээлийн жилд нийт 512 суралцагчтайгаар үйл ажиллагаа явуулж 2017 оны 12 сард 100 мэргэжилтэй ажилтныг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэн гаргасан болно. 2018 оны 04 дүгээр сарын байдлаар 412 суралцагч суралцаж байгаагаас хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд 362 суралцагч буюу 87,8% нь хамрагдсан болно.

**Хүснэгт 15 Суралцаж буй мэргэжил, суралцагчдын тоо**

| № | Мэргэжил | Индекс | Суралцагчдын тоо |
|---|---|---|---|
| ***Нийт*** | | | ***362*** |
| 1 | Автомашины засварчин | 8211-20 | 15 |
| 2 | Тогооч | 5120-11 | 50 |
| 3 | Оёмол бүтээгдэхүүний оёдолчин | 7533-28 | 48 |
| 4 | Барилгын цахилгаанин | 7411-12 | 31 |
| 5 | Үсчин | 5141-11 | 15 |
| 6 | Барилгын засал чимэглэл | 7123-20 | 35 |
| 7 | Барилгын сантехникч | 7126-36 | 9 |
| 8 | Нарийн бичгийн дарга, албан хэргийн ажилтан | 4120-11 | 30 |
| 9 | Барилгын өрөг угсрагч | 7112-19 | 13 |
| 10 | Ойжуулагч | 6210-21 | 13 |
| 11 | Гагнуурчин | 7212-14 | 19 |
| 12 | Барилгын мужаан | 7115-22 | 3 |

| | | | |
|---|---|---|---|
| 13 | Сийлбэрчин | 7323-28 | 5 |
| 14 | Уламжлалт мал аж ахуйн фермер | 6320-14 | 26 |
| 15 | Хүнд машин механизмын оператор | 8111-35 | 24 |
| 16 | Цахим тоног төхөөрөмжийн үйлчилгээний ажилтан | 7421-16 | 8 |
| 17 | Цэцэрлэгийн туслах багш | 5312-11 | 18 |

**Хүснэгт 16 Ерөнхий боловсролын сургуулийн 9-р анги төгсөгч, МСҮТ-д элсэгч, тоо, хувиар**

| Хичээлийн жил | ЕБС 9-р анги төгсөгчид | МСҮТ-д элсэгчид | МСҮТ-д элсэгчдийн хувь |
|---|---|---|---|
| 2015-2016 он | 857 | 101 | 11% |
| 2016-2017 он | 232 | 42 | 18% |
| 2017-2018 он | 468 | 71 | 15% |

**График 94 ЕБС-н 9-р анги төгсөгчдөөс МСҮТ-д элсэгчид сүүлийн 3 жилээр /хувь/**




Дундговь аймгийн Боловсрол соёл урлагийн газрын 2015-2018 оны статистик мэдээний үзүүлэлтээс харахад ерөнхий боловсролын сургуулийн 9 дугээр анги төгсөгчдөөс жилд дундажаар 14.6 хувь нь МСҮТ-д элсэн суралцаж байгаа нь МСҮТ-н элсэгчдийн тоог нэмэгдүүлэх талаар орон нутгийн бодлого шаардлагатай нь харагдаж байна.

Энэхүү судалгаанд Дундговь аймаг дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 362 суралцагч хамрагдсан ба оролцогчдыг нас, хүйсээр нь ангилан харуулбал:

График 96 Судалгаанд оролцогчид хүйсээр, хувь




График 95 Суралцагчдын насны ангилал, **хувь**



Судалгаанд оролцогчдын 26 хувь нь үндсэн 2.5 жилийн хугацаагаар мэргэжлийн боловсрол эзэмшигч үлдсэн 76 хувь нь насанд хүрэгчдийн буюу 1 жилийн ангийн суралцагч байгаа нь мэргэжлийн боловсролын сургалтын хэрэгцээ насанд хүрэгчдэд илүү шаардлагатай байна гэж дүгнэж байна.

**График 97 МСҮТ-н суралцагчдийн тоо, төгсөх хугацаа, 2018 он**

Дундговь аймгийн хөдөлмөрийн зах зээлд бэлтгэн нийлүүлэгдэх мэргэжилтэй ажилтны тоог харахад 2018 оны 06 дугаар сард хамгийн их төгсөгчдийг бэлтгэн гаргахаар харагдаж байна.




**График 98 МСҮТ-д суралцагчид сумд, хувиар**




МСҮТ-д 2017-2018 оны хичээлийн жилд нийт элсэгчдийн 63%-г Сайнцагаан, 37% үлдсэн 14 сум бүрдүүлж байгаа нь аймгийн МСҮТ-д сумдаас элсэгчдийн тоог нэмэгдүүлэх шаардлага байгааг харуулж байна.

**Хүснэгт 17 МСҮТ-д бэлтгэж байгаа мэргэжилтэй ажилтны эдийн засгийн үйл ажиллагааны салбар**

| № | Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал | МСҮТ-д мэргэжилтэн бэлтгэж байгаа салбар |
|---|---|---|
| 1 | Хөдөө аж ахуй | ✓ |
| 2 | Уул уурхай | ✓ |
| 3 | Боловсруулах үйлдвэр | |
| 4 | Цахилгаан, хий, уур, агааржуулалт | ✓ |
| 5 | Ус хангамж | |
| 6 | Барилга | ✓ |
| 7 | Бөөний болон жижиглэн худалдаа | ✓ |
| 8 | Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | |
| 9 | Зочид буудал байр нийтийн хоолны үйлчилгээ | ✓ |
| 10 | Мэдээлэл холбоо | ✓ |
| 11 | Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | |
| 12 | Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | |

| | | |
|---|---|---|
| 13 | Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | |
| 14 | Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | |
| 15 | Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа | |
| 16 | Албан журмын нийгмийн хамгаалал | |
| 17 | Боловсрол | ✓ |
| 18 | Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа | |
| 19 | Урлаг, үзвэр, тоглоом наадам | |
| 20 | Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | ✓ |
| 21 | Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа | |
| 22 | Олон улсын байгууллага суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | |

**График 99 МСҮТ суралцагчдын тоо, төгсөх хугацаа, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар 2018 он**




**График 100 МСҮТ-д суралцагчдын тоо, төгсөх хугацаа, мэргэжлээр**




Эзэмшсэн мэргэжлээ сонгоход нөлөөлсөн хүчин зүйлийг хамгийн чухлаас нь эхлэн 1-12 хүртэл эрэмбэлүүлэхэд:

Нийт 11 нөлөөллийг хүснэгтлэн жагсааж хамгийн чухал 1, дараагийн чухал 2 гэх мэтчилэн эрэмбэлүүлэн авсан ба нөлөөлөл бүр дээр авсан онооны нийлбэрийг харгалзан үзэж хамгийн бага нийлбэрийг чухал нөлөөтэй гэж үзсэн болно. Бусад гэсэн сонголт байсан ба нийт судалгаанд оролцогчдоос 59 суралцагч л бусад гэсэн сонголтыг үлдсэн 303 суралцагч бусад гэдэг сонголтыг сонгоогүй байсан.

Иймд судалгааны үр дүнд нөлөөлөл бага гэж үзэн хасаж харуулсан болно.

**График 101 Мэргэжлээ сонгоход нөлөөлсөн хүчин зүйлс нийлбэр оноогоор**




Тухайн суралцагч мэргэжлээ сонгон суралцахад мэргэжлийн нэр хүнд, мэргэжлээрээ ажиллахад авах цалин хөлс, суралцах үед олгодог тэтгэлэг, тэтгэмж гэсэн 3-н хүчин зүйл хамгийн чухал нөлөөлдөг байна.

Дээрх үзүүлэлтээс харахад суралцагчид нэр хүнд сайтай, цалин хөлс их авдаг мэргэжлийг сонгон суралцдаг байна.

Элсэн суралцагчдын хувьд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ болон эрэлт ихтэй мэргэжлийн талаарх мэдээлэл, сурталчилгааны ажил хүртээмжтэй түвшинд хийгдэхгүй байна гэж харагдаж байна.

3.7 Ажиллаж байгаа залуучуудаас АВСАН ТООН СУДАЛГААНЫ ДҮН

Энэхүү судалгаанд Дундговь аймгийн 15 сумын ажил эрхэлж буй 584 залуучууд хамрагдсан бөгөөд тэдгээрийн 163 буюу 27.9% нь эрэгтэй, 421 буюу 72.1% нь эмэгтэйчүүд /График №107/ байсан ба 0.5% нь 15 - 19 нас, 13.8% нь 20 - 24 нас, 41.3% нь 25 - 29 нас, 38.4% нь 30-35 нас, 6% нь 36 - аас дээш насныхан /График 106/ байна.

**График 102 Судалгаанд хамрагдсан залуусын хүйсийн харьцаа**




**График 103 Судалгаанд хамрагдсан залуусын нас**




Эдгээр залуучуудын 34 нь магистр, 379 нь бакалавр, 15 нь техникийн, 52 нь мэргэжлийн анхан шатны, 84 нь бүрэн дунд, 13 нь суурь, 3 нь бага боловсрол эзэмшсэн, 4 нь боловсрол эзэмшээгүй байна.

Судалгаанд хамрагдсан залуучуудаас 539 нь мэргэжил эзэмшсэн ба тэдний 28 нь хоёр буюу түүнээс дээш мэргэжил эзэмшсэн байна.

**График 104 Боловсролын түвшинг хувиар илэрхийлбэл**




**Хүснэгт 18, Ажиллаж буй залуучуудын тоо, эзэмшсэн мэргэжлээр**

| | Мэргэжил | Тоо | № | Мэргэжил | Тоо |
|---|---|---|---|---|---|
| 1 | Багш | **117** | 40 | Мэргэжилгүй | 45 |
| 2 | Нягтлан бодогч | **53** | 41 | Эмч | **32** |
| 3 | СӨБ багш | **30** | 42 | Хос мэргэжилтэй | 28 |
| 4 | Тогооч | **24** | 43 | Эрх зүйч, хуульч | 21 |
| 5 | Эдийн засагч | 20 | 44 | Архив бичиг хэргийн ажилтан Нарийн бичгийн дарга | 7 |
| 6 | Нийгмийн ажилтан | 13 | 45 | Хүнсний эрүүл ахуйч | 7 |
| 7 | Малын эмч, мал зүйч, зоо техникч | 12 | 46 | Эм зүйч | 6 |
| 8 | Сувилагч | 11 | 47 | Аялал жуулчлалын ажилтан | 6 |
| 9 | Компьютерийн операторчин, техник хангамж | 9 | 48 | Бизнесийн удирдлага | 6 |
| 10 | Компьютер, Программ хангамжын инженер | 7 | 49 | Газар зохион байгуулагч | 5 |
| 11 | Банк, санхүү | 6 | 50 | Цахилгааны инженер | 5 |
| 12 | Оёдолчин, зөөлөн эдлэлийн | 6 | 51 | Байгаль хамгаалагч | 4 |
| 13 | Жолооч | 5 | 52 | Төрийн захиргааны удирдлага | 4 |
| 14 | Цахилгаанчин | 5 | 53 | Инженер | 4 |
| 15 | Сантехникч, барилгын | 5 | 54 | Аврагч гал сөнөөгч | 3 |
| 16 | Худалдагч | 5 | 55 | Холбооны инженер | 3 |
| 17 | Гаалийн ажилтан | 4 | 56 | Автомашины засварчин | 2 |
| 18 | ХММО, жолооч | 3 | 57 | Экологич | 2 |
| 19 | Геологич | 3 | 58 | Хэл судлал | 2 |
| 20 | Гадаад харилцаа | 2 | 59 | Сэтгүүлч | 2 |
| 21 | Мужаан | 2 | 60 | Номын санч | 2 |
| 22 | Шаварчин, засал чимэглэлчин | 2 | 61 | Дуучин | 2 |
| 23 | Барилгын Өрөг угсрагч | 2 | 62 | Уул уурхайн инженер | 2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 24 | Галч | 2 | 63 | Төмөр замын засвар техник | 1 |
| 25 | Жижүүр | 2 | 64 | Ойжуулагч | 1 |
| 26 | Хоол үйлдвэрлэл Технологич | 2 | 65 | Орчуулагч | 1 |
| 27 | Улс төр судлаач | 2 | 66 | Буудагч | 1 |
| 28 | Сэтгэл судлаач | 2 | 67 | Боловсролын удирдлага | 1 |
| 29 | ХАА механикжуулалтын техникч | 2 | 68 | Соёлын менежер | 1 |
| 30 | Нарийн боовчин | 1 | 69 | Телевизийн найруулагч | 1 |
| 31 | Үсчин | 1 | 70 | Худалдааны менежер, маркетинг | 1 |
| 32 | Онцгой байдал гамшгаасхамгаалах | 1 | 71 | Жүжигчин | 1 |
| 33 | Архитектур | 1 | 72 | Бүжигчин | 1 |
| 34 | Гуталчин | 1 | 73 | Барилгын инженер | 1 |
| 35 | Сүлжигч | 1 | 74 | Усны инженер, Гидро механик | 1 |
| 36 | Эх бэлтгэгч | 1 | 75 | Үйлдвэрийн инженер технологич оёдол | 1 |
| 37 | Гар урлал | 1 | 76 | Дулааны инженер | 1 |
| 38 | Нярав | 1 | 77 | Автын инженер | 1 |
| 39 | Үйлдвэрийн техникч | 1 | 78 | Электроникийн инженер | 1 |

Мэргэжил сонгоход нөлөөлсөн хүчин зүйлийг хамгийн чухлаас нь эхлэн 1 - 12 хүртэл /хамгийн чухлыг 1, дараагийн чухлыг 2 гэх мэт/ эрэмбэлүүлэхэд

**Хүснэгт 19 Мэргэжил сонгоход нөлөөлсөн хүчин зүйл**

| Эрэмбэ | Мэргэжлээрээ ажиллахад авах цалин хөлс | Мэргэжлийн нэр хүнд өндөр | Тухайн мэргэжлийг их сурталчилж байсан | Төгсөөд шууд ажиллах боломжтой | Элсэхэд хялбар, босго оноо доогуур байсан | Гэр бүлийн уламжлалын дагуу сонгосон | Төгсөөд төрийн байгууллагад ажиллана | Эрэлт их мэргэжлүүдийн тухай мэдээлэлтэй | Ажил мэргэжлийн чиг баримжаа, зөвлөгөө авсан | Найз нөхдөөсөө зөвлөгөө авсан | Суралцах үед олгох тэтгэлэг, тэтгэмж | Бусад |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 94 | 56 | 27 | 125 | 21 | 41 | 42 | 51 | 21 | 16 | 13 | 12 |
| 2 | 46 | 92 | 37 | 85 | 17 | 31 | 75 | 53 | 41 | 21 | 22 | 1 |
| 3 | 46 | 61 | 53 | 79 | 27 | 26 | 57 | 70 | 39 | 21 | 15 | 3 |
| 4 | 57 | 50 | 57 | 50 | 20 | 30 | 56 | 55 | 62 | 25 | 19 | 0 |
| 5 | 44 | 51 | 50 | 37 | 42 | 24 | 42 | 60 | 50 | 42 | 20 | 0 |
| 6 | 51 | 38 | 61 | 33 | 30 | 52 | 37 | 36 | 51 | 29 | 27 | 1 |
| 7 | 42 | 36 | 45 | 25 | 34 | 26 | 33 | 27 | 42 | 56 | 31 | 5 |
| 8 | 37 | 30 | 46 | 24 | 33 | 26 | 22 | 34 | 41 | 38 | 36 | 9 |
| 9 | 6 | 5 | 8 | 4 | 6 | 12 | 3 | 7 | 7 | 6 | 7 | 2 |
| 10 | 2 | 3 | 1 | 3 | 9 | 1 | 1 | 3 | 4 | 14 | 6 | 3 |
| 11 | 4 | 0 | 0 | 2 | 11 | 2 | 1 | 1 | 0 | 6 | 14 | 0 |
| 12 | 155 | 162 | 199 | 117 | 334 | 313 | 215 | 187 | 226 | 310 | 374 | 548 |
| **1** | **3646** | **3617** | **4257** | **2957** | **5381** | **5019** | **4054** | **3912** | **4461** | **5281** | **5710** | **6760** |

График 105 Мэргэжил сонгоход нөлөөлсөн хүчин зүйлийн эрэмбэ




Судалгаанд хамрагдсан залуучууд энэхүү асуулгад хариулахдаа дутуу эрэмбэлсэн, зарим хариултыг хоосон орхисон байсан нь судалгааны дүнг боловсруулахад хүндрэл учруулж байлаа. Мэргэжил сонгоход нөлөөлөх хүчин зүйлийг чухлаас нь эхлэн 1 - 12 оноогоор эрэмбэлэх ёстой байсан тул хоосон орхисон хариултыг 12 оноогоор тооцож судалгааны үр дүнг боловсруулсан.

108, .

**График 107 Та мэргэжлээрээ ажиллаж байгаа эсэх, хувь**




**График 106 Мэргэжлээрээ ажиллаж буй эсэх, хувь**



Та мэргэжлээрээ ажиллаж байна уу? гэсэн асуултанд нийт судалгаанд хамрагдсан залуучуудын 364 нь буюу 62 хувь нь тийм, 220 буюу 38 хувь нь үгүй **/график 110/** гэж хариулсан байна. Төрийн байгууллагад мэргэжлээрээ ажиллаж байгаа залуучууд 72.3 хувь, хувийн байгууллагад мэргэжлээрээ ажиллаж байгаа залуучууд 38.3 хувь **/график 114/** байна.

**График 109 Шинэ боловсрол, мэргэжил эзэмших төлөвлөгөөтэй залуус**




**График 108 Шинэ боловсрол, мэргэжил эзэмших бол төгсөөд аймагтаа ажиллах эсэх**




Ажиллах боломжоо нэмэгдүүлэхийн тулд шинэ боловсрол, мэргэжил эзэмших төлөвлөгөөтэй байгаа юу? гэсэн асуултанд 473 нь буюу 81 хувь нь тийм, 111 буюу 19.0 хувь нь үгүй гэж хариулсан байна.

Харин хэрэв шинэ боловсрол, мэргэжил эзэмших бол сургуулиа төгсөөд аймагтаа ажиллах уу? гэсэн асуултанд хариулсан 473 хүнээс 429 буюу 90.7 хувь нь тийм, 36 буюу 7.6 хувь нь үгүй, 8 буюу 1.7 хувь нь хариулаагүй орхисон байна

**График 110 Мэргэжлээрээ ажиллахгүй байгаа шалтгаан**




**Хүснэгт 20 Мэргэжлээрээ ажиллахгүй байгаа шалтгаан**

| № | Мэргэжлээрээ ажиллахгүй байгаа шалтгаан | Тоо |
|---|---|---|
| 1 | Мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа | 113 |
| 2 | Мэдлэг ур чадвараар тэнцэхгүй байгаа | 5 |
| 3 | Ажил олгогчийн тавьсан шаардлагад тэнцэхгүй байгаа | 21 |
| 4 | Эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй байгаа | 4 |
| 5 | Цалин бага учраас | 13 |
| 6 | Бусад | 64 |

Мэргэжлээрээ ажиллахгүй байгаа шалтгааныг тодруулахад судалгаанд хамрагдсан залуучуудын 51 хувь нь мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа гэж хариулсан байна. Мөн бусад /сонирхолгүй, эрүүл мэндэд хортой ажлын байр, цалин тогтмол өгдөггүй гэх мэт шалтгаанууд / гэсэн хариулт 29.1 хувийг эзэлж байна.

Эндээс харахад залуучууд мэргэжлээ солих, дээшлүүлэх сонирхолтой байгаа бөгөөд анх мэргэжлээ буруу сонгосон эсвэл мэргэжлийн ур чадвар гологдсон, шинэ технологид суралцах сонирхолтой байна гэж дүгнэхээр байна.

Сүүлийн таван жилийн хугацаанд 114 залуу ажлаа өөрчилсөн байна. Энэ нь нийт судалгаанд хамрагдсан залуучуудын 19.6 хувь буюу 5 хүн тутмын 1 нь болж байна.

**График 111 Ажлаа өөрчилсөн залуучууд 5 хүн тутмын 1**



Цалин хөлс хэдэн хувиар нэмэгдэх тохиолдолд та ажлын байраа солих вэ? гэсэн асуултанд хариулсан залуучуудын хамгийн олон буюу 179 /30.7 хувь/ нь 50 хувь хүрч нэмэгдсэн тохиолдолд гэж хариулжээ.

**График 112 Цалин хөлс нэмэгдсэн тохиолдолд ажлын байраа өөрчлөх бодолтой залуучууд, хувь**




Нийт судалгаанд хамрагдсан залуучуудын 77 хувь нь цалин хөлс 50 хувиас дээш нэмэгдсэн тохиолдолд ажлын байраа солино гэж хариулсан байна.

**Хүснэгт 21 Ажиллах тохиромжтой нөхцөл**

| Эрэмбэ | Өндөр цалин хөлс | Албаны унаа, гар утас | Эрүүл мэндийн даатгал | Сургалт | Хоол, унааны зардлын хөнгөлөлт | Өндөр шагнал | Хүүхдийн цэцэрлэг, яслийн төлбөр | Өндөр насны нэмэлт тэтгэврийн | Орон сууцаар хангах | Нэмэгдэл амралт | Бусад |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 370 | 6 | 77 | 27 | 0 | 0 | 0 | 5 | 63 | 13 | 6 |
| 2 | 78 | 39 | 8 | 78 | 22 | 11 | 25 | 14 | 111 | 33 | 2 |
| 3 | 40 | 33 | 58 | 104 | 47 | 12 | 45 | 29 | 87 | 66 | 3 |
| 4 | 22 | 42 | 142 | 83 | 66 | 32 | 45 | 42 | 66 | 56 | 4 |
| 5 | 22 | 57 | 87 | 59 | 91 | 35 | 57 | 37 | 46 | 71 | 3 |
| 6 | 0 | 60 | 77 | 50 | 86 | 55 | 58 | 39 | 25 | 53 | 5 |
| 7 | 2 | 52 | 44 | 47 | 68 | 67 | 66 | 50 | 32 | 43 | 6 |
| 8 | 8 | 53 | 41 | 28 | 51 | 79 | 49 | 78 | 21 | 45 | 6 |
| 9 | 2 | 52 | 21 | 25 | 35 | 73 | 62 | 69 | 21 | 31 | 7 |
| 10 | 3 | 49 | 18 | 14 | 18 | 67 | 41 | 80 | 13 | 74 | 9 |
| 11 | 37 | 141 | 11 | 69 | 100 | 153 | 136 | 141 | 99 | 99 | 533 |
| Дүн | **1377** | **4293** | **2504** | **3099** | **3899** | **4802** | **4316** | **4653** | **2990** | **3943** | **6186** |

**График 113 Эрэмбээр жагсаавал**




Ажиллах хамгийн тохиромжтой нөхцлийг хамгийн чухлаас нь эхлэн 1 - 11 хүртэл оноогоор эрэмбэлүүлэхэд өндөр цалин хөлс, эрүүл мэндийн даатгал, орон сууцаар хангах, сургах гэсэн 4 нөхцөл хамгийн чухал болох нь харагдаж байна. **/Хүснэгт 21, Зураг ..../**

## БҮЛЭГ 4 ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН ТООН СУДАЛГААНД ХИЙСЭН ДҮГНЭЛТ

Судалгаанд 354 ААН байгууллага хамрагдсан. Тэдгээрийн 90% буюу 320-нь 1-9 ажилтантай, 142 буюу 44.3% -нь бөөний болон жижиглэн худалдаа, 18-нь буюу 5.6% -нь зочид буудал зоогийн газрын үйлчилгээ эрхэлж байхад, 13 нь буюу 4 % нь боловсруулах үйлдвэр эрхэлж байгаа нь манай аймагт **ихэвчлэн худалдаа эрхэлдэг, жижиг аж ахуй нэгжүүд үйл ажиллагаа явуулдаг** болохыг харуулж байна. **Хүснэгт 4**

Мөн эдгээр ААНБ-ын 158 буюу 45% нь үйл ажиллагаагаа өргөжүүлнэ**:** гэсэн бөгөөд 38% худалдаа, 17.7% боловсруулах үйлдвэрлэл, 9.5% ХАА, 20% үйлчилгээний бусад чиглэлээр өргөжүүлэхээр төлөвлөж байна. **График 21**

**Хүснэгт 22 Ойрын 3 жилд судалгаанд хамрагдсан ААНБ-уудад хамгийн эрэлттэй ажлын байранд шинээр авах ажилтны тоо, мэргэжлээр**

| № | Мэргэжлийн нэр | Салбар код | 2018 | 2019 | 2020 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Уул уурхайн ММ оператор | 2 | 31 | 30 | 40 | 101 |
| 2 | Худалдааны туслах ажилтан | 7 | 22 | | 1 | 23 |
| 3 | Зочид буудал зоогийн газрын туслах | 9 | 19 | | | 19 |
| 4 | Барилгын туслах | 6 | 13 | | 5 | 18 |
| 5 | Худалдагч | 7 | 13 | 2 | 2 | 17 |
| 6 | Нягтлан бодогч | 11 | 14 | 1 | | 15 |
| 7 | Тогооч | 9 | 12 | 1 | 1 | 14 |
| 8 | Барилгын өргөн | 6 | 12 | 1 | | 13 |
| 9 | Эрчим хүчний инженер техникийн ажилтан | 4 | 12 | | | 12 |
| 10 | Малын их эмч | 1 | 9 | | | 9 |
| 11 | Хүнсний нарийн мэргэжлийн ажилтан | 9 | 9 | | | 9 |
| 12 | Авто Засварчин | 7 | 5 | 3 | | 8 |
| 13 | Шүдний техникч | 18 | 7 | | | 7 |
| 14 | Талх, нарийн боовчин | 20 | 4 | 1 | 1 | 6 |
| Нийт **/А/** | | | 182 | 39 | 50 | 271 |
| Судалгаагаар гарсан нийт эрэлт **/Б/** | | | 241 | 58 | 51 | 350 |
| Нийт эрэлтэд эзлэх хувь **Б/А** | | | 76% | 67% | 98% | 77% |

Хамгийн эрэлттэй 14 мэргэжлээр бий болох ажлын байрны тоо нь судалгаагаар тогтоогдсон шинээр бий болох нийт ажлын байрны 77%-ийг эзэлж байна. Мэргэжлээр нь задалж үзвэл уул уурхайн машин механизмын оператор, худалдаа, худалдааны туслах ажилтан, барилга, зочид

буудал, зоогийн газрын туслах, тогооч, эрчим хүчний инженер техникийн ажилтан хамгийн өндөр хувьтай байна.

**График 114 Судалгаанд хамрагдсан нийт ААНБ-д ойрын 3 жилд шинээр бий болох ажлын байрны тоо, хувиар**




Нийт 350 ажлын байр бий болохоос 69 % нь 2018 онд байна.

2019, 2020 онд бага байгаа нь тухайн ААНБ-ын төлөвлөлт сайн хийгдээгүй байгаатай холбож ойлгож болох юм.

Үйл ажиллагаагаа өргөжүүлж, ажлын байр шинээр бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхээр төлөвлөж байгаа ААНБ-д хэрэгцээтэй дэмжлэгийг цаг алдалгүй үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

*Харин судалгаанд хамрагдсан нийт 436* ***ХХЭ-ийн 65% нь үйлдвэрлэл, үйлчилгээний*** *салбарт, 46 нь буюу 10.6 % нь бөөний болон жижиглэн худалдаа эрхэлж байгаа нь зэрэг үзүүлэлт юм.*

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн аймгийн нийт хүн амд эзлэх хувь нь бага ч, /График 36/ 53.8% нь 36-55 насныхан, 45.8% нь бүрэн дунд, 15.1% нь мэргэжлийн, 13.5% нь суурь боловсролтой иргэд эзэлж байгаа нь **суурь болон дунд боловсролтой хөдөлмөрийн насны иргэд үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр голчлон хувиараа хөдөлмөр эрхэлж байна.** График 37, 38-аас харж болно.

Мөн ХХЭ-ийн 45 хувь нь өөрийн хөрөнгөөр, 50 хувь нь банкны зээл, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр, 5 % нь бусад эх үүсвэрээс санхүүжилт авч үйл ажиллагаагаа эхлүүлсэн, харин ажилтны хувьд 51 % нь 1 ажилтантай, 31% нь 2-3 ажилтантай байна.

Судалгаанд хамрагдсан нийт 436 хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 179 нь буюу 41% нь цаашид аж ахуйн нэгж болж үйл ажиллагаагаа өргөжүүлэх хүсэлтэй, 31% нь цаашид шинээр ажилтан авна гэсэн байна. График 53

**Хүснэгт 23 Ойрын 3 жилд судалгаанд хамрагдсан ХХЭ-д хамгийн эрэлттэй ажлын байранд шинээр авах ажилтны тоо, мэргэжлээр**

| № | Эзэмшсэн мэргэжил | Салбар | ХХЭрхлэгч | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2018 | 2019 | 2020 | Нийт |
| 1 | Тогооч | 9 | 26 | 3 | | 29 |
| 2 | Уламжлалт мал аж ахуйн фермер/туслах малчин | 1 | 25 | | | 25 |
| 3 | Гоо сайханч, холбогдох бусад ажилтан | 20 | 12 | 5 | 1 | 18 |
| 4 | Оёдолчин, зөөлөн эдлэлийн | 20 | 13 | 3 | | 16 |
| 5 | Мужаан | 3 | 11 | 1 | | 12 |
| 6 | Худалдагч | 7 | 10 | | | 10 |
| 7 | Зөөгч, бармен | 9 | 2 | 4 | | 6 |
| 8 | Зочид буудал, зоогийн газрын туслах ажилтан | 9 | 6 | | | 6 |
| 9 | Үсчин | 20 | 5 | 1 | | 6 |
| 10 | Нягтлан бодогч | 11 | 5 | | | 5 |
| 11 | Нарийн боовчин | 20 | 3 | 2 | | 5 |
| 12 | Жимс ногооны мэргэжилтэн | 1 | 1 | 3 | | 4 |
| 13 | Гагнуурчин | 4 | 3 | 1 | | 4 |
| 14 | Автомашины засварчин | 7 | 2 | 2 | | 4 |
| 15 | Дугуй завсарчин | 7 | 4 | | | 4 |
| Нийт **/А/** | | | 128 | 25 | 1 | 154 |
| Судалгаагаар гарсан нийт эрэлт **/Б/** | | | 148 | 31 | 1 | 180 |
| Нийт эрэлтэд эзлэх хувь **Б/А** | | | 86% | 81% | 100% | 86% |

ХХЭ-ийн хувьд дараах мэргэжлүүд хамгийн эрэлттэй байна. Үүнд: тогооч 29, зөөгч бармен 6, зочид буудал, зоогийн газрын ажилтан 6, нарийн боовчин 5 нийт 46, үсчин 6, гоо сайханч 18, оёдолчин 16, мужаан 12

*Цаашид ХХЭ-дийг үйл ажиллагаагаа өргөжүүлэх, хоршиж, нэгдэж, томрох, зах зээлээ өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, нь орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах, ядуурлаас сэргийлэх зөв шийдэл байж болох юм.*

**График 116 ХЗЗ-ийн нийлүүлэгч, хувиар**




**График 115 ХЗЗ-ийн эрэлт, хувиар**




Мэргэжил эзэмшсэн ажилгүй иргэдийн тоо 1121 байгаа нь ХЗЗ-д илүүдэл үүсэхэд нөлөөлж байна. Харин эрэлтийн 37%-ийг ажил олгогчид, 63% буюу 1151 ажлын байр ойрын 3 жилд улсын болон орон нутгийн төсвөөр хийгдэх томоохон бүтээн байгуулалтаас бий болохоор төлөвлөгдөж байна.

*Иймд ажилгүй, мэргэжил эзэмшсэн иргэдийн мэдлэг, ур чадварыг үнэлэх, мөн ирээдүйд шинээр бий болох ажлын байрны шаардлагад нийцүүлэн давтан сургаж, мэргэшүүлэх, зуучлах ажлыг зохион байгуулж, ажилгүйдлыг бууруулах нь зүйтэй гэж дүгнэж байна.*

График 22 Ажилтан авахад тулгардаг бэрхшээл, хувиар




График 23 Ажил олгогчийн ажилтанд тавьж буй шаардлага, тоо хувь




Ажил олгогчид /ААНБ/ ажилтан авахад тулгардаг бэрхшээл: Хандлага 32%, мэдлэг хангалтгүй 10%, ур чадвар тааруу 20% байгаа нь нийт хариултын 62 % нь болж байна. Харин ажил олгогчоос ажилтанд тавьдаг 6 шаардлагын 5 нь буюу 85% харилцаа, хандлагатай, 15% нь ур чадвартай холбоотой байна.

График 14-өөс сүүлийн 3 жилд ажилтны тоонд өөрчлөлт орсон ААНБ 66 буюу судалгаанд хамрагдсан ААНБ-ын 18.6% нь байсан. Эдгээрийг салбараар авч үзэхэд 28 нь буюу 42% нь бөөний болон жижиглэн худалдаа, 7 буюу 11 % нь зочид буудал зоогийн газрын үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг ААНБ байна.

Харин ажилтан ажлаас халсан ХХЭ-н тоог эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд хамгийн өндөр 36.7 хувь буюу 22 нь "Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар"-т үйл ажиллагаа явуулж буй ХХЭ, 26.7 хувь буюу 16 нь "Зочид буудал, байр нийтийн хоолны үйлчилгээний салбар"-т үйл ажиллагаа явуулж буй хувиараа хөдөлмөр эрхлэгчид байна. Зочид буудал, байр, нийтийн хоолны үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй ХХЭ иргэд /График 47/ ажилтнаа тогтвортой ажиллуулж чадахгүй байна. Судалгаанд хамрагдсан ААН байгууллагууд мэргэжлийн сургалтын байгууллагатай хамтран ажилтнуудынхаа мэргэжлийн зэрэг ахиулах, давтан сургалтад хамруулах сонирхол давамгайлж байна. /График 31, 32-оос

Ажилгүй иргэдийн мэдлэг, ур чадвар ажил олгогчийн шаардлага хангахгүй байгаа мөн ажил олгогчид ажилтан авахад тулгамдаж буй бэрхшээл зэргээс харахад мэргэжилтэй ажилтан бэлтгэх болон мэргэшүүлэх сургалтыг ажил олгогчийн шаардлагад нийцүүлж, чанарыг дээшлүүлэх шаардлагатай юм. Энэ шаардлагыг хангахад ажил олгогч, сургалтын байгууллага, суралцагчийн идэвх, оролцоо, хамтын ажиллагаа чухал үр нөлөөг үзүүлэх болно.

харах/

**График 117 Туслах малчинтай, малчингүй, малчин авах, авахгүй малчин өрхийн тоо**




Одоогоор судалгаанд хамрагдсан нийт малчин өрхийн 6% нь туслах малчинтай байна. Ойрын 3 жилд туслах малчин авах хэрэгцээтэй өрхийн тоо 154 буюу судалгаанд хамрагдсан өрхийн 22% байгаа нь энэ салбарт ажлын байр шинээр бий болох нь тодорхой харагдаж байна.

График 69 өөс харахад малчин өрхийн 48 хувь нь 48% нь хоршоо, нөхөрлөл болж, хөдөлмөр, хүчээрээ нэгдэн ажиллах сонирхолтой байна

*Ажил олгогч малчин өрхийн туслах малчинд тавьж буй шаардлагад нийцсэн ажилтанг бэлтгэх, зуучлахад анхаарал хандуулж ажиллах шаардлага гарч байна. /График 64-оос харах/*

График 82, 83-аас харахад судалгаанд хамрагдсан иргэдийн 66% нь 24 сараас дээш хугацаагаар ажил хөдөлмөр эрхлээгүй, ажилгүй байсан шалтгаан ы 48% нь мэргэжилгүй, мэргэжилд тохирох ажил олдоогүй гэсэн байна. График 84, ажил олгогчийн шаардлага хангаагүй, мэргэжилийн ур чадвар хүрэлцэхгүй гэсэн шалтгааны улмаас 24-өөс дээш сар ажилгүй байгаа гэсэн иргэдийн тоо олон байна. График 85. Ажилгүй иргэдийн 35.5 хувь нь төрийн байгууллагад, 35.2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй байна. График 86, 87 . ажилгүй иргэд нь хувиараа хөдөлмөр эрхлэхэд 63% нь барьцаа хөрөнгө бага шаарддаг, хүү багатай зээл, 27% нь тоног төхөөөрөмжийн дэмжлэг хэрэгтэй гэсэн бөгөөд тэдний 44 хувь нь ажиллаж байсан туршлагагүй байна. Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн суралцах хэрэгцээг хамгийн өндөр үзүүлэлтээр авч үзэхэд: 147 тогооч, 114 оёдолчин /зөөлөн эдлэлийн/, 59 гагнуурчин, 55 жолооч, 56 нягтлан бодогч мэргэжлээр суралцах сонирхолтой байна

*Ажилгүй иргэдийн өнөөгийн нөхцөл байдлыг нарийвчлан шинжилж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, өөрсдийнх нь эзэмшсэн мэргэжил, ур чадвар, сонирхолд үндэслэн ажил олгогчийн шаардлагад нийцүүлэн мэргэшүүлэх, чадавхжуулах үе шаттай хөтөлбөрийг олон талын оролцоотойгоор боловсруулж, хэрэгжүүлэх*

Ажиллах хүчний нийлүүлэлт, орон нутгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулах бүлэг бол одоо их дээд сургуульд суралцаж байгаа оюутан залуучууд юм. Судалгаагаар /график 89/ 2018-2022 онд суралцаж, төгсөх нийт 1469 залуучууд байна. Тэдний 44% нь төгсөөд орон нутагдаа ажиллана. 28% нь хаана ажиллахаа шийдээгүй байна гэжээ. Ажиллах хүчний энэ нөөцийг татахад орон нутгийн хөгжлийн бодлого, түүний хэрэгжилтийн үр дүнд бий болох шинэ ажлын байр, шинээр эрхлэх хөгжүүлэх бизнесийн чиглэлийн тухай мэдээллээр тэднийг хангаж,

уриалан дуудах арга хэмжээг зохион байгуулах  нь үр дүнтэй. Мөн цаашид орон нутгийн хөдөлмөрийн зах  зээлд эрэлттэй мэргэжил сонгох, мэргэжлийн чиг баримжаа авахад зориулсан мэдээллийг дунд сургуулийн сурагч, эцэг эх, боловсролын байгууллагуудад тогтмол хүргэж байж орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэртэй байлгах нөхцөл бүрдэнэ.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлөх бас нэг хүчин зүйл нь  одоо ажиллаж байгаа залуучууд юм. Энэхүү судалгаанд Дундговь аймгийн 15 сумын ажил эрхэлж буй 584 залуучууд хамрагдсан байна.

**Хүснэгт  24 ажиллаж байгаа залуучуудын тоо, мэргэжлээр**

| № | Мэргэжил | Тоо | эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Багш | **117** | 20% |
| 2 | Нягтлан бодогч | **53** | 9% |
| 40 | Мэргэжилгүй | 45 | 8% |
| 41 | Эмч | **32** | 5% |
| 3 | СӨБ багш | **30** | 5% |
| 42 | Хос мэргэжилтэй | 28 | 5% |
| 4 | Тогооч | **24** | 4% |
| 43 | Эрх зүйч, хуульч | 21 | 4% |
| 5 | Эдийн засагч | 20 | 3% |
| 6 | Нийгмийн ажилтан | 13 | 2% |
| 7 | Малын эмч, мал зүйч, зоо техникч | 12 | 2% |
| 8 | Сувилагч | 11 | 2% |
| | *Дүн* | 406 | 70% |

Судалгаанд хамрагдсан 584 залуучуудын 20% нь багш, 9% нь нягтлан бодогч хийж байна. Эдгээр 9 мэргэжлээр хамгийн олон буюу 406 залуучууд ажиллаж байгаа ба энэ нь нийт судалгаан хамрагдсан залуучуудын 70%-ийг эзэлж байна. Судалгааны үр дүнгээс харахад залуучууд төгсөөд шууд ажиллах боломжтой, нэр хүнд сайтай, өндөр цалинтай мэргэжлүүдийг сонгон суралцсан байна . График106 График 108, 107 эдгээр залуусын 62% нь эзэмшсэн мэргэжлээрээ ажиллаж байна. Төрийн албанд ажиллаж байгаа залуучууд ихэвчлэн мэргэжлээрээ, харин хувийн хэвшилд ажиллаж байгаа залуучуудын 62.7 % нь мэргэжлээрээ ажилладаггүй юм байна.

*Залуучуудын 81% нь дахин суралцах төлөвлөгөөтэй, мөн одоо суралцаж байгаа залуучуудын  44% нь орон нутагтаа ажиллах хүсэлтэй зэрэг нь ХЗЗ-ийн тогтворгүй байдлыг харуулж байгаа тул залуучуудын ажиллах таатай нөхцөлийг судлан хүний нөөцийн хэтийн бодлого, төлөвлөлтийг хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага урган гарч байна.*

**Хүснэгт 25 Улс, орон нутгийн төсвөөр хийгдэх томоохон бүтээн байгуулалтын үр дүнд бий болох ажлын байрны эрэлт, нийлүүлэлтийн судалгаа, мэргэжлээр**

| Мэргэжил | ХЗЗ-ийн эрэлттэй ажлын байрны тоо, мэргэжлээр | | | | | | | | | | ХЗЗ-ийн нийлүүлэлт, мэргэжлээр | | | | | ХЗЗ-ийн илүүдэл (..), хомсдол | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ААНБ | | | ХХЭрхлэгч | | Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтаас | | | | Нийт | Ажилгүй иргэд | МСҮТөвийн суралцагчид, төгсөлтийн он, сараар | | | ИДС | | | |
| | 2018 | 2019 | 2020 | 2018 | 2019 | 2020 | 2018 | 2019 | 2020 | | | 2018.06 | 2018.12 | 2019.12 | | 2018 | 2019 | 2020 |
| **Зөөгч, бармен** | 1 | | | 2 | 4 | | 72 | 81 | 105 | 265 | 1 | | | | | 74 | 84 | 104 |
| **Гар урлал** | | | | 3 | | | 50 | 55 | 60 | 168 | 1 | | | | | 52 | 54 | 59 |
| **Хүнсний эрүүл ахуйч** | 9 | | | | 1 | | 40 | 40 | 40 | 130 | 1 | | | | | 48 | 40 | 39 |
| **Хоол үйлдвэрлэл Технологич** | | | | | | | 34 | 50 | 52 | 136 | 3 | | | | 6 | 31 | 47 | 49 |
| **Оёдлын Технологич** | | | | | | | 30 | 32 | 35 | 97 | 2 | | | | | 28 | 30 | 33 |
| **Оёдолчин, зөөлөн эдлэлийн** | 2 | 3 | | 13 | 3 | | 85 | 90 | 100 | 296 | 47 | 25 | 13 | 10 | | 28 | 36 | 43 |
| **Аялал жуулчлалын үйлчлэх ажилтан, үйлчлэгч** | | | | | | | 23 | 38 | 44 | 105 | | | | | | 23 | 38 | 44 |
| **Мах сүүний технологич** | | | | | | | 10 | 10 | 20 | 40 | 3 | | | | | 7 | 7 | 17 |
| **Үсчин** | | | | 5 | 1 | | 16 | 24 | 30 | 76 | 37 | 18 | | | | (34) | (12) | (7) |
| **Тогооч** | 12 | 1 | 1 | 26 | 3 | | 50 | 95 | 140 | 328 | 115 | 26 | 12 | 10 | | (53) | (28) | 16 |

Дундговь аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсээс гаргасан судалгаагаар хоол, хүнсний үйлдвэрлэл, гар урлал, оёдлын чиглэлээр ажлын байр шинээр бий болохоор харагдаж байна. Харин эдгээр мэргэжлээр МСҮТ –д зөвхөн оёдолчин , тогооч, үсчинээр мэргэжилтэй ажилтан бэлтгэдэг, үсчин, тогооч мэргэжлээр өмнө бэлтгэгдсэн ажилгүй иргэд олон байдаг тул илүүдэлтэй харагдаж байна. Иймд томоохон хөрөнгө оруулалтын үр дүнд шинээр бий болох ажлын байрны тоо болон чанарын судалгааг сайн хийж, шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтанг шинээр болон давтан сургах ажлыг орон нутагт яаралтай зохион байгуулах шаардлагатай байна.

**Хүснэгт 26 Дундговь аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн матриц, ойрын 3 жил, эдийн засгийн салбараар**

| Салбарын Код | Салбар | Ойрын 3 жилийн эрэлт | | | | | | | | | | | | | Ойрын 3 жилийн нийлүүлэлт | | | | ХЗЗ-ийн илүүдэл () /хомсдол ойрын 3 жилд | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Ажил олгогч | | | ХХЭрхлэгч | | | Туслах малчин | | | Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтаас | | | Нийт | Ажилгүй иргэд | МСҮТөвийн суралцагчид, төгсөлтийн он, сараар | | | | | |
| | | 2018 | 2019 | 2020 | 2018 | 2019 | 2020 | 2018 | 2019 | 2020 | 2018 | 2019 | 2020 | | | 2018.06 | 2018.12 | 2019.12 | 2018 | 2019 | 2020 |
| 1 | ХАА, ойн АА, загас барилт, ан агнуур/тариаланч, ногоочин, малчин, амьтан маллагч, газар тариаланч, фермч | 3 | 0 | 0 | 27 | 3 | 0 | 154 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 187 | 9 | 42 | 0 | 0 | 133 | (6) | (9) |
| 9 | Зочид буудал, байр,нийтийн хоолны үйлчилгээ/Хоол үйлдвэрлэл, караоке бар/ | 45 | 1 | 1 | 34 | 8 | 0 | 0 | 0 | 0 | 196 | 266 | 337 | 888 | 120 | 26 | 12 | 10 | 129 | 143 | 208 |
| 20 | Үйлчилгээний бусад үйл ажиллагаа/алт мөнгөний дархан, үсчин гоо сайханч,оёдол, эсгий сүлжмэл эдлэл, талх нарийн боов/ | 8 | 6 | 2 | 42 | 11 | 1 | 0 | 0 | 0 | 191 | 211 | 245 | 717 | 115 | 53 | 13 | 10 | 73 | 100 | 123 |
| 21 | Олон улсын байгууллага суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | | | | 23 | 38 | 44 | 106 | 1 | 0 | 0 | 0 | 23 | 37 | 43 |
| 18 | Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа/эх баригч, сувилахуйн мэргэжилтэн, эмийн сан, малын эмч | 32 | 4 | 1 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 39 | 35 | 0 | 0 | 0 | (1) | (31) | (34) |
| 5 | Ус хангамж: Бохир ус зайлуулах, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 0 | 0 | 0 | (2) | (2) | (2) |
| 2 | Уул уурхай, олборлолт/Бичил уурхай/ | 36 | 30 | 40 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 106 | 13 | 28 | 0 | 0 | -5 | 17 | 27 |
| 12 | Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 6 | 0 | 0 | 0 | (6) | (6) | (6) |
| 14 | Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 3 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 3 | 10 | 0 | 0 | 0 | (7) | (10) | (10) |
| 15 | Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа | | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 12 | 0 | 0 | 0 | (12) | (12) | (12) |
| 13 | Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 17 | 0 | 0 | 0 | (17) | (17) | (17) |
| 7 | Бөөний болон жижиглэн худалдаа: /Машин болон мотоциклын засвар,дугуй засвар | 45 | 6 | 2 | 16 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 71 | 56 | 0 | 8 | 11 | (18) | (56) | (65) |
| 19 | Урлаг, үзвэр, тоглоом наадам/кино театр, рс тоглоомын газар/ | | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 19 | 0 | 0 | 0 | (19) | (19) | (19) |
| 16 | Албан журмын нийгмийн хамгаалал | | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 25 | 0 | 0 | 0 | (25) | (25) | (25) |
| 3 | Боловсруулах үйлдвэр/Блок,тоосго, модон эдлэл, ноос, арьс ширээр үйлдвэрлэгч/ | | 2 | 0 | 13 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 16 | 39 | 0 | 0 | 0 | (26) | (36) | (39) |
| 10 | Мэдээлэл холбоо | 2 | 2 | 0 | 3 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 8 | 32 | 0 | 0 | 10 | (28) | (30) | (43) |
| 11 | Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 18 | 1 | 0 | 5 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 24 | 79 | 0 | 0 | 0 | (56) | (78) | (79) |
| 4 | Цахилгаан, хий, уур, агааржуулалт/гагнуурын үйл ажиллагаа/ | 13 | 0 | 0 | 3 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 17 | 63 | 24 | 0 | 0 | (71) | (62) | (63) |
| 17 | Боловсрол /сургалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчид, номын санч, архивч/ | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 120 | 53 | 0 | 0 | (171) | (120) | (120) |
| 6 | Барилга /Барилгачин, өрөгч, хэв цутгагч г.мэт/ | 29 | 6 | 5 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 42 | 161 | 51 | 20 | 42 | (181) | (175) | (198) |
| 8 | Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа/ачаа болон хүн тээврийн үйлчилгээ / | 4 | 0 | 0 | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 6 | 187 | 0 | 0 | 0 | (181) | (187) | (187) |
| | Нийт дүн | 241 | 58 | 51 | 149 | 27 | 1 | 154 | 0 | 0 | 410 | 515 | 626 | 2232 | 1121 | 277 | 53 | 83 | (468) | (575) | (527) |
| | Мэргэжилгүй | | | | | | | | | | | | | | 844 | | | | | | |

Цаашид орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг тодорхой хугацаанд тогтмол хийж, мэдээллийг олон нийтэд түгээж, бодлого боловсруулахад ашиглах боломж, нөхцөлийг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт төсөвт байгууллагын 35.5%, ААН-ийн 4.2% -нь хөдөлмөрийн зах зээлийн LMIS програмд бүртгэлтэй байна. Цаашид энэ програмыг ХЗЗ-ийн судалгаа хийх найдвартай эх үүсвэр болгон ашиглах боломжтой. Үүнтэй холбоотойгоор Дундговь аймгийн ХХҮГын хийсэн судалгаанаас харахад:

**График 118 Дундговь аймагт үйл ажиллагаа явуулдаг ААНБ-ын тоо, 2018 оны 06 сарын байдлаар**




**График 119 Дундговь аймгийн нийт ААНБ-ын тоо, хувиар, LMIS програмд бүртгэгдсэн байдлаар**




Аймгийн ХХҮГ LMIS програмд бүртгэлд ААНБ-ын хамрагдах хувийг үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байна

Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг хөдөлмөрийн хувийн биржийн болон аймаг, сумын хөдөлмөр, халамж үйлчилгээний ажилтнуудыг чадавхжуулах нь энэхүү зорилгыг хангах, орон нутгийн чадавхийг бэхжүүлэх зөв арга замын нэг юм.

**График 120 ХЗЗ судалгааны асуулгыг LMIS прогамын асуулгатай харьцуулсан тоо, хувиар**




Хөдөлмөрийн зах зээлийн 93 асуулгын 40 буюу 43%-ийг LMIS програмын бүртгэлийг бүрэн төгс хийхэд гаргаж авах боломжтой. Үлдсэн 57 хувийг нэмэлт судалгаагаар авах шаардлагатай.

*Нэмэлт судалгаа хийхэд зөвхөн ХХҮГ-ийн ажилтнуудаас гадна ХХААГ, МСҮТ, Татварын хэлтэс, статистикийн хэлтэс, МБС-ын Говийн бүсийн арга зүйн төв болон бусад хөдөлмөр эрхлэлтийн дэмжигч ТББ-ууд, ХАҮТ, Нийгмийн даатгалын хэлтэс зэрэг байгууллагын ажилтнуудын оролцоотойгоор бүрдүүлсэн хөдөлмөрийн зах зээлийн судалгааны багийг бүрэн чадавхжуулах нь орон нутгийн чадавхийг бэхжүүлэх, энэ үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах хамгийн чухал гарц юм.*

График 14-өөс харахад сүүлийн 3 жилд ажилтны тоонд өөрчлөлт орсон ААНБ 66 байсан. Эдгээрийг салбараар авч үзэхэд 28 нь буюу 42% нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, зочид буудал зоогийн газрын үйлчилгээний салбарт 7 буюу 11 % нь үйл ажиллагаа явуулдаг ААНБ байна.

Шинээр ажилд орсон ажилтанд 192001-250000 цалин олгодог 60, 250001-450000 цалин олгодог 55 ААНБ байгаа нь нийт хариултын 72%-ийг эзэлж байгаа бөгөөд шинэ ажилтны цалин бага байдаг гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Судалгаанд хамрагдсан ААНБ-ын 81.1% нь их дээд сургууль, МСҮТ, коллеж төгсөгчдөөс ажилтанаар авч ажиллуулаагүй, 18.9% нь ажилтан авч ажиллуулсан байна. Судалгаанд яагаад их дээд сургууль, МСҮТ, коллеж төгсөгчдөөс ажилтан авч ажиллуулаагүй шалтгааныг тодруулах асуулга оруулаагүй. Цаашид яагаад ажилтан авч ажиллуулахгүй байгаа шалтгааныг тодруулах чанарын судалгаа хийх шаардлагатай. /график 23/

Судалгаанд хамрагдсан ААН байгууллагууд МСҮТ-тэй хамтран мэргэжлийн зэрэг ахиулах, давтан сургалтад ажилтнуудаа хамруулах сонирхол давамгай байгаа нь мэргэшүүлэх, давтан сургалтын эрэлт их байгааг харуулж байна. Тиймээс дахин сургалтын хэрэгцээ тодорхойлох судалгаа хийх шаардлагатай байна.

Ажиллаж буй залуучуудаас авсан судалгаанд ажиллах хамгийн тохиромжтой нөхцөлийг хамгийн чухлаас нь эхлэн 1-11 хүртэл оноогоор эрэмбэлүүлэхэд өндөр цалин хөлс, эрүүл мэндийн даатгал, орон сууцаар хангах, суралцах гэсэн 4 нөхцөл хамгийн чухал болох нь харагдаж байна. Ажилтнууд нийгмийн баталгаагаа сайжруулах, сурч боловсрох талаар ажил олгогчоос хүлээлт өндөр байдаг байна.

ААНБ-ын удирдлагууд үйлдвэрлэлийн хөгжилд 24% нь санхүүгийн менежментийн ур чадвар, 21% нь удирдлагын ур чадвар, 17% нь маркетингийн ур чадвар чухал гэж хариулсан байна.

Судалгаанд хамрагдсан ХХЭ иргэдийг боловсролын түвшингээр харвал хамгийн их буюу 45.8% нь бүрэн дунд боловсролтой, 15.1% нь мэргэжлийн боловсролтой, 13.5% нь суурь боловсролтой иргэд байна. Үүнээс үзэхэд 36-55 насны бүрэн дунд боловсролтой иргэд хувиараа хөдөлмөр эрхэлж байна. Хувиараа хөдөлмөр эрхэлж буй 36-с дээш насны иргэд 5-с дээш жил үйл ажиллагаа эрхэлж буй нь нас тогтсон иргэдийн хувьд үйл ажиллагаа тогтвортой явуулдаг, 35-с доош насны залуучуудын хувьд аж ахуй шинээр эхэлж буйг илтгэж байна.

Цалин олгож ажилтан ажиллуулж буй 131 хувиараа хөдөлмөр эрхлэгч байна. Үүнээс 67 буюу 51.1% нь 1 ажилтантай, 41 буюу 31.3% нь 2-3 ажилтантай, 12 буюу 9.2% нь 4-5 ажилтантайгаар үйл ажиллагаа эрхэлж байна. /График 42/

Цалинтай ажилтан ажиллуулдаг хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 75 буюу 57.3% нь 300 мянга хүртэл төгрөгийн цалин, 5 буюу 3.8% нь 450 мянган төгрөгөөс дээш цалин олгодог байна. /График 44/

Судалгаанд хамрагдсан ХХЭ-н 31% буюу 137 нь шинээр ажилтан авна, 69% буюу 229 нь ажилтан авахгүй гэж хариулсан. Ажилтан авах хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 36.4% нь ажилд хариуцлагатай хандах хандлагыг, 15.3% нь ажлын ачаалал даах чадварыг, 33.5% нь дээрх ур чадваруудыг бүгдийг харна гэсэн байна. /График 53, 54/

Судалгаанд хамрагдсан нийт 436 ХХЭ-ийн 65% нь үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт, 46 нь буюу 10.6 % нь бөөний болон жижиглэн худалдаа эрхэлж байгаа нь эерэг үзүүлэлт юм. Иймд ХХЭ-ийг бодлогоор дэмжиж, үйл ажиллагааг нь өргөжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

ААН болж өргөжихгүй гэж хариулсан 257 ХХЭ-ийн 57.6% нь ААН болох шаардлагагүй, 26.5% нь хувиараа хөдөлмөр эрхлэх нь хялбар, 8.2% нь ААН болох мэдлэг дутмаг гэж хариулсан ба энэ нь хувиараа хөдөлмөр эрхлэх нь тэдэнд хялбар байдгийг харуулахын зэрэгцээ ААН болохын ашиг тус, албан секторт шилжих, хариуцлагын хэлбэрийн талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан малчин өрхийн тэргүүлэгчдийн 93% нь бага, суурь, бүрэн дунд боловсролтой, 61-ээс дээш настай малчдын 60% нь бага боловсролтой байна. Харин 36-60 насныхны хувьд суурь боловсролтой малчны эзлэх хувь өндөр байгаа нь нэгдэлжих

хөдөлгөөний үед 8-р анги төгсөгчид илгээлтээр мал аж ахуйн салбарт гарч байсантай холбоотой байх боломжтой. 1983-1992 онд төрсөн малчдын дунд бага боловсрол эзэмшигчдийн эзлэх хувь их байгаа нь өмч хувьчлал, нийгмийн шилжилттэй холбоотой байж болох юм. 1992-2003 онд төрсөн малчдын хувьд дээд, техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшигчдийн эзлэх хувь тодорхой хувиар нэмэгдэж байгаа нь иргэдийн хөдөө рүү чиглэсэн эерэг хандлага бий болж эхэлж байгааг харуулж байна. /График 59/

Мал аж ахуйн үйлдвэрлэлд оролцогчдыг хүйсээр харвал 67% нь эрэгтэй, 33% нь эмэгтэй байна. Үүнээс харахад мал аж ахуйн үйлдвэрлэлд эмэгтэйчүүд бага оролцож байгаа нь харагдаж байна. /График 60/ Малчин өрхийн үйлдвэрлэлд 35-60 насны малчдын тоо ихэнх хувийг эзэлж байгаа ба залуу малчдын эзлэх хувь бага байгаа нь цаашид залуу малчдыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна. /График 62/

Судалгаанд хамрагдсан малчин өрхийн 22% буюу 154 өрх туслах малчин авах шаардлагатай гэж хариулжээ. /График 64, хүснэгт 9/

Туслах малчин авах хэрэгцээтэй малчид туслах малчиндаа малч, хөдөлмөрч, итгэл даах, гэр бүлтэй, тогтвор суурьшилтай ажиллах шаардлагыг нэн тэргүүнд тавьж байна. /График 68/

Судалгаанд хамрагдсан нийт малчин өрхийн 46.4% нь цаашид нөхөрлөл, хоршоо болон өргөжиж хамтран үйл ажиллагаагаа өргөжүүлэх сонирхол давамгай байна. /Хүснэгт 10/

Малчдын сургалтын хэрэгцээг харахад судалгаанд хамрагдсан малчдын 27.6% нь мал аж ахуйн сургалт, 14.2% нь малын эрүүл мэндийн сургалт, 11.2% нь малч ухааны сургалт шаардлагатай, харин сургалт хэрэггүй, мэдэхгүй гэсэн хариултын эзлэх хувь бага буюу 4.5% байгаа нь малчид хөгжих, мал аж ахуйн салбарын шинэлэг зүйлийг суралцах, үйлдвэрлэгч болох хүсэл эрмэлзлэл их байгааг харуулж байна.

Энэ удаагийн судалгаанд төсвийн байгууллага хамрагдаагүй тул зарим мэргэжлийн эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлох боломжгүй байсан. Цаашид хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд төсвийн байгууллагуудыг хамруулах шаардлагатай байна.

Дундговь аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлж, ямар мэргэжил эрэлттэй, аль нь нийлүүлэлтийн илүүдэлтэй байгааг 3-р бүлэгт хүснэгтээр харуулсан.

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсээс гаргасан мэдээллээс харахад 2018-2020 онд зочид буудал, байр, нийтийн хоолны үйлчилгээний салбарт 799 ажлын байр /зөөгч бармен 258, тогооч 285, хоол үйлдвэрлэлийн технологич 136, хүсний эрүүл ахуйч 120/, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 647 ажлын байр /гар урлалын ажилтан 165, мах, сүүний технологич 40, оёдлын технологич 97, зөөлөн эдлэлийн оёдолчин 275, үсчин 70/, аялал жуулчлалын үйлчилгээний ажилтан 105 ажлын байр шинээр бий болохоор харагдаж байна.

Ажил олгогчид зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээний салбарт 47, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 53, уул уурхай, олборлолтын салбарт 106, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт 37 /малын эмч, зоо техникч энэ салбарт багтсан/, бусад салбарт 107 нийт 350 ажлын байр, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд МАА салбарт 30, боловсруулах үйлдвэрийн салбарт 14, зочид буудал, байр, нийтийн хоолны салбарт 42, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 54, бусад салбарт 37 нийт 177 ажлын байр тус тус бий болгохоор харагдаж байна.

Эрэлтийн тоон судалгааны дүнг ашиглахдаа орон нутгаас барьж буй бодлого, ААНБ, ХХЭ-ийн эрэлтээс гадна ажилгүй иргэдийн суралцах хүсэл, сонирхлыг бас харгалзах нь зүйтэй. Ажилгүй иргэдээс авсан судалгаанаас харахад тогооч 147, зөөлөн эдлэлийн оёдолчин 114, үсчин 84, гагнуурчин 59, цахилгаанчин 42 зэрэг мэргэжлээр суралцах сонирхолтой хүн олон байна.

Ажил эрхэлдэггүй иргэдээс авсан судалгаанаас харахад жолооч 153, тогооч 115, багш 79, шаварчин, засалчин 79, зөөлөн эдлэлийн оёдолчин 54 зэргээр нийлүүлэлтийн илүүдэл бий болсон байна. Судалгаанд хамрагдсан ажилгүй иргэдийн 44 хувь ажлын туршлагагүй, 56 хувь нь хувийн хэвшил, төрийн байгууллагад ажиллаж байсан туршлагатай байгаа нь ажлын байранд шууд ажиллаж чадах хүний нөөц бэлэн байгааг харуулж байна.

Эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харахад нийлүүлэлтийн илүүдэлтэй мэргэжлээр эрэлт гараад байгаа ажил олгогч нягтлан бодогч /11/, худалдагч касс, нярав /15/ мэргэжилтэй ажилтан

хөдөлмөрийн зах зээлээс олж чадаагүй /график 17/, гэтэл судалгаанд хамрагдсан ажилгүй /хүснэгт 14/ нягтлан бодогч мэргэжилтэй 31 иргэн, худалдагч, касс, нярав мэргэжилтэй 22 иргэн байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээл дээр бэлтгэгдсэн мэргэжилтэй ажилтан байсаар байтал ажил олгогч олддоггүй гэж хариулсан, мөн энэ чиглэлийн мэргэжилтэй ажилгүй иргэд ажил хайж байгаа нь ажил олгогч, ажилгүй иргэд мэдээлэл муутай, эдгээрийг холбох үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай мөн орон нутагт ажлын байр хомс байгаа тул Улаанбаатар болон бусад аймагт бий болж буй ажлын байрыг судлан зуучлалын үйлчилгээг тэлэх шаардлагатай байгааг харуулж байна.

